



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”-НД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/131-ШТА-ГА

Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа иргэдийн саналгүй арга хэмжээг баталдаг байдал жил бүр давтагдаж байгаа бөгөөд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.tailan.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: : 70442424 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор Д.Цэдэвцэвээн
Утас: : 70442424 цахим хуудас: tsedevtseveend@audit.gov.mn

Аудитор А.Адилзаяа
Утас: : 70442424 цахим хуудас: adilzayaa@audit.gov.mn

Аудитор :Д.Оюун-Эрдэнэ
Утас: : 70442424 цахим хуудас: Oyunerdened@audit.gov.mn

Тайланг хянасан:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Тайланг бэлтгэсэн:
Аудитын менежер М.Алтантуяа

Ахлах аудитор Б.Должмаа

Аудитор Д.Цэдэвцэвээн

Аудитор А.Адилзаяа

Аудитор Д.Оюун-Эрдэнэ

2025 оны 06 дугаар сарын 16-ний өдөр

Тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот
15160
Монгол Улс

АГУУЛГА	
БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМАГТ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН ХУВААРИЙН ДАГУУ БҮРЭН ОЛГООГҮЙ БАЙНА.	6
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДАД ХӨРӨНГӨ ХУДАЛДАН АВАХ, АРД ИРГЭДЭД ТУСЛАМЖ ОЛГОХОД ЗАРЦУУЛДАГ БАЙДЛЫГ ТАСЛАН ЗОГСООЖ, ОРОН НУТАГТ ҮР ӨГӨӨЖТЭЙ, БОДИТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	15
2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтыг мөрдөөгүй, хариуцлагыг тооцохгүй байгаа нь ажлууд чанаргүй хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	15
2.2. Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрсэн байна.	21
2.3. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг төсөвт байгууллагууд бүрэн ашиглаагүй, нийтийн эзэмшлийн талбайд бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүйгээс хөрөнгийн үр нөлөө гараагүй байна.	25
БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗДТГ-УУД ХЯНАЛТ ТАВЬЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	26
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 76.2 хувьд аймаг, сумын ИТХ, 97.4 хувьд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, 92.0 хувьд нь захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй байна.	26
3.2. Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.3, 9.9 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	31
ДҮГНЭЛТ	35
САНАЛ	36
ЗӨВЛӨМЖ	38

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МЭГ	Мал эмнэлгийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл арга хэмжээ
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХДАГ	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
БХБХ	Барилга хот байгуулалтын хэлтэс
БОНХОБТХ	Бүс орон нутаг хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХОБХТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ТАГ	Төрийн аудитын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс

Хүлээн авсан баримтын жагсаалт

Байгууллагын нэр	Ирүүлсэн баримтын нэр
Баянхонгор аймгийн ЗДТГ	- ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн санхүүжилтийн эрх (сараар) - Баянхонгор аймгийн ИТХ-ын тогтоолууд /анхны, тодотгосон/ - Баянхонгор аймгийн ЗДТГ-аас сумдад олгох ОНХС-ийн сар, улирлын хуваарь - Баянхонгор аймгийн ОНХС-ийн 2024 оны дансны хуулга - Баянхонгор аймгийн ОНХС-аас олгосон зардлын анхан шатны баримтууд - Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг орлогод бүртгэх тухай ИТХ-ын даргын захирамжууд - Нэгдсэн судалгаа - Худалдан авах ажиллагааны баримтууд
Сумдын ЗДТГ	- Сумдын ИТХ-ын тогтоолууд /анхны, тодотгосон/ - ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт - Нэгдсэн судалгаа - Сумын ОНХС-ийн дансны хуулга - ОНХС-ийн анхан шатны баримтууд

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах” тухай А/108 дугаар тушаалуудыг үндэслэн аудитыг гүйцэтгэв. Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэв. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянасан, тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Баянхонгор аймгийн болон 20 сумын ОНХС-ийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулж, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллав. Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: - Төсвийн тухай хууль - Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/; - Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;

Хүндрэл бэрхшээл

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
 - Малын тоо толгойн албан татварын тухай хууль;
 - Төрийн хэмнэлтийн тухай хууль;
 - Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
 - Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”;
 - Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
 - Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
 - Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
 - Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
 - Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
- Аймаг, сумдын ОНХС хариуцсан холбогдох албан тушаалтнууд солигдсон байна.

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМАГТ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН ХУВААРИЙН ДАГУУ БҮРЭН ОЛГООГҮЙ БАЙНА.

1.1. ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д 21,577.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 20,790.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 787.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу хуваарилсан байна.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг орон нутгийн түвшинд тодорхой мэдээлэл байхгүй тул ОНХС-ийн нэгтгэсэн тайланд авч үзнэ.

1.1.2. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д 21,577.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 20,790.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 787.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу хуваарилсан байна.

Дүрслэл:1 ОНХНС-аас олгосон санхүүжилт улирлаар



Сангийн яамнаас Баянхонгор аймагт олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг баталж гаргасан боловч гүйцэтгэлээр сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй, орлогын шилжүүлгийн 8.4 хувийг I дүгээр улиралд, 26.3 хувийг II дугаар улиралд, 24.8 хувийг III дугаар улиралд, 40.6 хувийг IV дүгээр улиралд шилжүүлсэн байна.

Оны сүүл буюу IV дүгээр улиралд санхүүжилтийг хамгийн өндөр дүнгээр хуваарилан олгох үйл явц жил бүр давтагдаж байгаа нь тухайн онд

төлөвлөсөн төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, улирлын шинж чанартай төсөл арга хэмжээнүүд он дамжих эрсдэл буурахгүй байгаа тул эхний хагас жилд санхүүжилтийг олгодог байх нь зүйтэй байна.

1.1.3. Баянхонгор аймаг болон аймгийн 20 сумд ОНХНС-ийн шилжүүлгээр 2024 онд 20,790.0 сая төгрөг орсныг хуваарийн дагуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3¹ дахь заалт, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу Баянхонгор аймагт хуваарилагдсан 20,790.0 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс 7,631.3 (36.7%) сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 13,178.8 (63.3%) сая төгрөгийг 20 сумын ОНХС-д хуваарилсан байна.

Сумдад олгосон дүнгээс харахад Шинэжинст сум нийт шилжүүлгийн 13.7 хувь буюу 2,849.5 сая төгрөг, Баянхонгор сум 7.3 хувь буюу 1,524.1 сая төгрөг, Баян-Өндөр сум 6.7 хувь буюу 1,401.1 сая төгрөгөөр 2024 онд олгосон нь хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ болон ашигт малтмал, газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс харьцангуй өндөр дүнгээр

¹ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

шилжүүлэг хийгдсэнийг илтгэж байна. Харин хамгийн бага орлогын шилжүүлэг хийгдсэн нь Заг сум 1.1 хувь буюу 220.8 сая төгрөг, Богд сум 1.2 хувь буюу 247.8 сая төгрөг, Баянбулаг сум 1.2 хувь буюу 257.0 сая төгрөг байгаа нь эдгээр сумд нь хүн ам цөөн, газар нутаг харьцангуй бага, ашигт малтмалын талбай хязгаарлагдмал байгаатай холбоотой байна.

Хүснэгт 1. Аймаг, сумдад олгохоор баталсан ОНХС-ийн шилжүүлэг (сая төг)

№	Сумдын нэр	Орлогын шилжүүлэг		Урамшуулал		Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100%, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7/		Нийт	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	2	3	4	5	6	9	10	11	12
1	Баацагаан	383.8	362.0			2.8	2.8	386.6	364.8
2	Баянбулаг	206.1	190.7	54.2	54.2	12.0	12.0	272.3	257.0
3	Баянговь	848.4	780.5	83.4	83.4	271.0	271.0	1,202.8	1,134.9
4	Баянлиг	644.0	598.3	124.9	124.9	40.4	40.4	809.3	763.6
5	Баян-Овоо	354.0	329.4			79.2	79.2	432.9	408.5
6	Баян-Өндөр	1,211.7	1,127.9	131.0	131.0	142.3	142.3	1,485.0	1,401.1
7	Баянхонгор	1,378.6	1,287.3	236.8	236.8			1,615.5	1,524.1
8	Баянцагаан	541.0	504.8			101.7	101.7	642.7	606.5
9	Богд	262.6	247.8					262.6	247.8
10	Бөмбөгөр	452.5	417.9	57.4	57.4	103.6	103.6	613.5	578.9
11	Бууцагаан	357.5	337.2			2.5	2.5	360.0	339.8
12	Галуут	424.0	397.8			39.3	39.3	463.3	437.2
13	Гурванбулаг	271.0	251.2	66.6	66.6	12.0	12.0	349.6	329.8
14	Жаргалант	290.7	273.6			13.5	13.5	304.2	287.0
15	Жинст	315.8	296.9			21.0	21.0	336.8	317.9
16	Заг	182.2	169.1	48.6	48.6	3.1	3.1	233.9	220.8
17	Өлзийт	407.0	378.3	48.9	48.6	53.3	53.3	508.9	480.8
18	Хүрээмарал	251.9	233.7	53.9	53.9	16.0	16.0	321.7	303.6
19	Шинэжинст	2,340.5	2,176.7	123.0	123.0	556.5	549.6	3,020.1	2,849.5
20	Эрдэнэцогт	323.9	305.7			0.1	0.1	324.0	305.8
21	Баянхонгор аймаг	7,631.3	7,631.3					7,631.3	7,631.3
Нийт		19,078.2	18,298.1	1,028.5	1,028.5	1,470.3	1,463.5	21,577.0	20,790.0

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

Засгийн газрын 2023 оны 457 дүгээр тогтоолоор ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлалаар сумдад хөрөнгийг хуваарилсан бол олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал нь гүйцэтгэлийн үнэлгээгээр, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого нь тухайн сумын ОНХС-ийн үйл ажиллагаа, тухайн нутагт байрлах тусгай зөвшөөрлөөс хамаарч харилцан адилгүй хуваарилагдсан байна.

1.1.4. Баянхонгор аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр төлөвлөсөн байна.

Баянхонгор аймаг, сумдын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2² болон “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2³-т заасны дагуу 2024 онд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг 21,577.0 сая төгрөгийг ОНХНС-аас, 10,951.9 сая төгрөгийг бусад эх үүсвэрээр орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Эх үүсвэрийг төрөл тус бүрээр нь авч үзвэл ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг хамгийн өндөр хувь буюу 58.7 хувийг эзэлж байгаа нь сумд бие даах чадвар сул байгааг харуулж байна.

² Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ
³ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

Хүснэгт 2. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр (сая төг)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Эзлэх хувь
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	19,078.2	58.7
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	24.4	0.7
3	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	1,445.9	2.6
4	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал	1,028.5	3.8
5	ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	2,210.2	11.2
6	ТТХ-ийн 60.2.5 "тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"	5,858.9	15.5
7	Малын тоо толгойн татвар	1,468.4	6.2
8	Бусад орлого	1,414.3	6.0
ДҮН		32,528.8	100

Эх сурвалж: Баянхонгор аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3⁴-т заасны дагуу нийт сумдын ОНХС-ийн 2023 оны төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан 2024 онд 1,028.5 сая төгрөгийн урамшуулал олгохоор төлөвлөснийг хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

Дээрх урамшууллын 2024 оны гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл Баянхонгор сум 23 хувь, Баян-Өндөр сум 12.7 хувь, Баянлиг сум 12.1 хувь Шинэжинст сум 12 хувиар буюу хамгийн өндөр урамшуулал авч ОНХС-ийн эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байхад бусад сумд ОНХС-ийн эх үүсвэрээ нэмэгдүүлж чадаагүй байна. Иймээс ТЕЗ, ИТХ болон холбогдох албан тушаалтнууд сум орон нутгийнхаа ОНХС-ийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад анхаарал хандуулах шаардлагатай байна.


Дүрслэл 2: Сумдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээ



Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

⁴ орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5⁵-т заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 2024 онд ОНХС-ийн эх үүсвэрт нийт 5,858.9 сая төгрөгийн хандивын орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг холбогдох гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс нийт 2,510.7 сая төгрөгийн орлого орсон нь




төлөвлөлттэй харьцуулахад 3,348.3 сая төгрөгөөр буюу 57.1 хувиар тасарсан байна. Энэ нь уул уурхайн компаниудтай байгуулсан гэрээ, санамж бичгийн хэрэгжилт хангалтгүй байх, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаатай холбоотой байна. Иймээс ОНХС-ийн орлогыг төсөвлөхдөө эх үүсвэр нь тодорхойгүй хандивын орлогыг төлөвлөхгүй байхад анхаарах нь зүйтэй байна.

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

1.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн санал аваагүй, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, магадлалаар баталгаажаагүй, төсөвлөлтийн үндэслэл, шаардлагыг хангаагүй, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллага, шинжээчээр хянуулаагүй, иргэдийн саналд тулгуурлаагүйгээр төсөл арга хэмжээ баталдаг зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.

1.2.1. Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зөрчил жил бүр илэрч байна.

Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 655 төсөл арга хэмжээг баталснаас 54 төсөл арга хэмжээ нь иргэдийн санал аваагүй байна. Үүнээс газар зүйн байрлалаар авч үзвэл дараах байдалтай байна.



✓ Баянхонгор аймаг 34, Баян-Өндөр сум 9, Бууцагаан сум 2, Баян-Овоо сум 2, Богд сум 2, Бөмбөгөр сум 2, Шинэжинст сум 2, Баянговь сум 1 төсөл арга хэмжээг тус тус иргэдийн санал аваагүй байхад төлөвлөж баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 24/22 дугаар тогтоолоор иргэдийн санал аваагүй 595.2 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг баталж, үүнээс 5 арга хэмжээг хэрэгжүүлж, хөрөнгө зарцуулсан;

- Баянговь сумын ИТХ-ын 2024 оны 21/01 дугаар тогтоолоор баталсан 49.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Сумын төвийн камержуулалт" төсөл арга хэмжээнд иргэдийн санал аваагүй;

- Бууцагаан сумын ИТХ-ын 2024 оны 17/12 дугаар тогтоолоор баталсан 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Соёлын төвийн гутал, хувцас хийх" 17.5 сая төгрөгийг төсөвт өртөг бүхий "Хүндэтгэлийн гэрийн буурь цутгах" төсөл арга хэмжээнүүд иргэдийн санал аваагүй;


⁵ " тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"

- Шинэжинст сумын ИТХ-ын 2024 оны 126 дугаар тогтоолоор баталсан 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Зураг төсөв /сумын план зураг/", 12.4 сая төгрөгийн "Худаг /халуун ус/" зэрэг төсөл арга хэмжээнүүд иргэдийн санал аваагүй;
- Баянхонгор аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Баянхонгор аймагт 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг батлахдаа иргэдээс санал аваагүй 2,131.6 сая төгрөгийн 34 төсөл арга хэмжээг баталсан ба өмнөх жил тус зөрчил илэрч албан шаардлага өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй;
- Богд сумын ИТХ-ын 2024 оны 17/17 дугаар тогтоолоор баталсан 60.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хогийн машин худалдан авах", 8.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хог хаягдлын менежмент" зэрэг арга хэмжээнүүд нь иргэдийн санал аваагүй;
- Баян-Овоо сумын ИТХ-ын 2024 оны 15/01 дугаар тогтоолоор 100.0 сая төгрөгийн "Хог хаягдал цэвэрлэх", 40.0 сая төгрөгөөр "3-4 дүгээр гудамжны засварын ажил" төсөл арга хэмжээг иргэдийн саналгүйгээр төлөвлөж, баталсан;
- Бөмбөгөр сумын ИТХ-ын 2024 оны 19/10 дугаар тогтоолоор 20.0 сая төгрөгийн "Цаг уурын станцыг хашаажуулах", 32.5 сая төгрөгөөр "Сургуулийн хичээлийн байрны гадна дотно камержуулалт, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг" зэрэг төсөл арга хэмжээг иргэдийн саналгүйгээр төлөвлөж, баталсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5⁶, 16 дугаар зүйлийн 16.5.5⁷, 60 дугаар зүйлийн 60.3.6⁸ дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2⁹, 4.7.5¹⁰ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ-д “Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлсэн захирагчаас өргөн барьсан төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа ТЭЗҮ хийгээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, иргэдээс санал аваагүй төсөл арга хэмжээг батлахгүй байх” асуудлыг аймаг, сумдын ИТХ-д толилуулсан болно.

Дүрслэл 4: Иргэдээс авсан санал асуулга



Аудитын явцад Google forms ашиглан Баянхонгор аймаг, сумдын 1963 иргэнээс ОНХС-ийн 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ иргэдийн идэвх, оролцоо, саналыг үндэслэсэн эсэхэд дараах санал асуулгыг явуулсан. Үүнд:

1. Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 78 хувь нь тийм, 22 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Дүрслэл 5: Иргэдээс авсан санал асуулга


⁶ “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: хариуцлагатай байх

⁷ “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁸ “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ


⁹ “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

¹⁰ “Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ



2. Та 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний мэдээллийг ямар эх сурвалжаас авсан бэ? гэсэн асуултад багийн иргэдийн нийтийн хурлаас 969, фэйсбүүк, сошиал медиагаас 399, мэдээлэл аваагүй 292, гэр бүл, ажлын хамт олноос 285, бусад 18 оролцогч хариулсан хариулсан байна.

Дүрслэл 6: Иргэдээс авсан санал асуулга



3. 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг та ямар хэлбэрээр өгсөн бэ? гэсэн асуултад Багийн иргэдийн нийтийн хурал дээр цаасаар 746, бүлгийн ярилцлага 61, ОНХС-ийн гар утасны аппликейшн 1023, санал өгөөгүй 80, бусад хариулт өгсөн 53 иргэн байна.

Дээрх санал асуулгаас харахад иргэдийн идэвх оролцоо өмнөх оноос 14.2 хувиар өссөн, цахим хэрэглээний цаг үеийг даган ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системийн гар утасны аппликейшнаар иргэд саналаа өгөх байдал нь нэмэгдсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу сумын Засаг дарга нар захирамж гаргаж төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулж, иргэдээс ирүүлсэн саналыг шат, шатны ИТХ-д толилуулсан байна.

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан баталсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9¹¹, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2¹², 63.3¹³, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1¹⁴, 4.3.1, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.4¹⁵-т заасныг үндэслэн аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан баталсан боловч төсөл арга хэмжээг батлахдаа төсөвт өртгийг жижиглэн төлөвлөдөг зөрчил бүрэн арилахгүй байна.

¹¹ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

¹² Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

¹³ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

¹⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

¹⁵ орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

Баянхонгор аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр 25,107.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 555 арга хэмжээ баталсан байна. Үүнээс 0-20.0 сая төгрөгөөр санхүүжих 367 төсөл арга хэмжээ нь нийт төсөл арга хэмжээний 66.2 хувийг эзэлж байна.

Дүрслэл 7. 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, төсөвт өртгөөр (сая төг)



Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

Тайлант онд хэрэгжүүлэхээр шинээр баталсан 20.0 сая төгрөг хүртэлх зардлын дүнтэй 367 төсөл арга хэмжээнд дүн шинжилгээ хийхэд 3.0 сая төгрөг хүртэл зардалтай 14, 3.1-5.0 сая төгрөгийн зардалтай 60, 5.1-10.0 сая төгрөгийн зардалтай 58, 10.1-20.0 сая төгрөгийн зардалтай 235 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд эдгээрээс цэцэрлэг, сургуулийн зөөлөн эдлэл худалдан авах, шал засварлах, бохирын шугам шинэчлэх, хашаа, хайс хийх, автомашины засвар үйлчилгээ хийх зэрэг төсөвт байгууллагуудын урсгал зардлаас санхүүжүүлэх боломжтой зардлыг баталсан байна.

Баянхонгор аймаг, Баянхонгор сумын ОНХС-аас иргэдэд гэр, оёдлын машин, хүлэмж, зуух олгох, эко нойл барих, хоёр айлын дээврийн засвар хийх зэрэг халамжийн шинжтэй арга хэмжээг баталж, санхүүжүүлсэн нь тухайн сангийн зорилго, зориулалттай нийцэхгүй байх эрсдэлтэй тул цаашид ийм төрлийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Дээрх төсөл арга хэмжээнд хамрагдах иргэдийг сонгохдоо олон нийтэд нээлттэй зарлаагүй байсан тул Баянхонгор сумын ОНХС-аас санхүүжүүлсэн оёдлын машин, хүлэмж авсан 21 иргэнийг түүврийн аргаар сонгож, хөрөнгийн үр нөлөөг тандах зорилгоор санал асуулга авахад санал асуулгад оролцогчдын 71.4 хувь нь хөрөнгө авах тухай өргөдөл бичсэн, 14.2 хувь нь баг, хорооноос сонгогдсон бол 14.2 хувь нь танил талаараа хөөцөлдөж авсан гэж хариулсан байна.

Шийдвэрлэлт: ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиг төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан нь орон нутгийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн томоохон хөрөнгө оруулалтын шинж чанартай, ажлын байр нэмэгдүүлэх, төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр орон нутгийн иргэдийн орлого нэмэгдэх, амьдрах аятай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөл арга хэмжээг батлахыг шат шатны ИТХ-д толилуулав.

1.2.3. Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй, ТЭЗҮ, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ, газрын зөвшөөрөл зэргийг шийдээгүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6¹⁶, 29 дүгээр зүйлийн 29.4¹⁷ заалтыг зөрчин зураг төсөв батлаагүй, ТЭЗҮ хийлгээгүй, газар шийдэгдээгүй, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй 2,787.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг баталсан, үүнээс 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажлыг хэрэгжүүлсэн зөрчилтэй байна. Энэ нь төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжийг хааж, сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулах, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг эрсдэлийг бий болгож байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 920.0 сая төгрөгийн Галуут сумын спорт заалны барилгын ажлын газар шийдэгдээгүй, 130.0 сая төгрөгийн Эрдэнэцогт сумын шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн ажил, 50.0 сая төгрөгийн ахмадын өргөөний засварын ажил, 150.0 сая төгрөгийн Өлзийт сумын бага Шаргалжуутын үүрэн холбооны сүлжээний өргөтгөл, 30.0 сая төгрөгийн Баянхонгор сумын 10 дугаар багийн иргэдийн цахим мэдээллийн нэгдсэн систем зэрэг төсөл арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолтыг бүрэн хийгдээгүй байхад аймгийн ИТХ-аар баталсан;
- Баянговь сумын спорт заалны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холболтын зураг хийгдээгүй нэг хэв маягийн зураг ашигласнаас төсөв баталсан дүнгээс нэмэгдсэн байна;
- Баянлиг сумын ИТХ-аар “Бага баян ууланд 4G сүлжээ тавих” төсөл арга хэмжээг зураг төсөвгүй байхад 207.0 сая төгрөгөөр баталсан;
- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулсан албан тушаалтны гарын үсгээр баталгаажаагүй;
- Баянлиг сумын Соёлын төвд 14.3 сая төгрөгийн 100 нэр төрлийн номыг худалдан авах техникийн тодорхойлолтыг үндэслэлгүй боловсруулснаас гүйцэтгэлээр 38 нэр төрлийн номыг өөр номоор орлуулсан авсан байна.

Шийдвэрлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, баталгаажуулсан, төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан төсөл арга хэмжээг батлахыг аймаг, сумдын ИТХ-д толилуулав.

1.2.4. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2, 4.3-т заасан аймаг, сумын чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээг баталж, санхүүжүүлсэн өмнөх онуудын зөрчлийг давтан гаргасан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр 32,528.8 сая төгрөгийн 655 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шат, шатны ИТХ-аар баталж, гүйцэтгэлээр 22,215.2 сая төгрөгийг зарцуулсан байна.


Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 12,107.2 сая төгрөгийн нийт 100 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 79 төсөл арга хэмжээнд 9,220.9 сая төгрөгийн санхүүжилт олгосныг журмын 4.2-т заасан чиг үүргийн дагуу ангилан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

¹⁶ Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ

¹⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

Дүрслэл 8.Баянхонгор аймгийн ОНХС-ийн зарцуулалт /ТАХ тоогоор/



✓ Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологид 3,018.1 сая төгрөгийн 33 ТАХ

✓ Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 3,131.0 сая төгрөгийн 17 ТАХ

✓ Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 1,485.1 сая төгрөгийн 13 ТАХ

✓ Ундны усны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулахад 482.6 сая төгрөгийн 6 ТАХ

✓ Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахад 172.2. сая төгрөгийн 2 ТАХ

✓ Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэхэд 330.0 сая төгрөгийн 2 ТАХ



✓ Ажлын байр бий болгоход 20.0 сая төгрөгийн 1 ТАХ

✓ Журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй 582.0 сая төгрөгийн 5 ТАХ-г санхүүжүүлсэн байна. (Хавсралт судалгаа-9 “Сум ТАХ БНАТАГ”)

Дүрслэл 9.Баянхонгор аймгийн ОНХС-ийн зарцуулалт /ТАХ тоогоор/

Харин 20 сумын хэмжээнд нийт 20,421.6 сая төгрөгийн 555 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 12,592.3 сая төгрөгийн 403 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 7,498.0 сая төгрөгийн 57 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд байна. Үүнээс тайлант онд хэрэгжүүлж, хөрөнгө зарцуулсан 445 төсөл арга хэмжээг ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.3-т заасан чиг үүргийн дагуу ангилан авч үзвэл

✓ Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологид 3,052.5 сая төгрөгийн 78 ТАХ

✓ Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 1,977.7 сая төгрөгийн 49 ТАХ

✓ Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 3,381.2 сая төгрөгийн 103 ТАХ

✓ Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулахад 797.9 сая төгрөгийн 32 ТАХ

✓ Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахад 202.5 сая төгрөгийн 12 ТАХ

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

- ✓ Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэхэд 82.4 сая төгрөгийн 8 ТАХ
- ✓ Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалтад 82.4 сая төгрөгийн 6 ТАХ
- ✓ Ажлын байр бий болгоход 168.9 сая төгрөгийн 8 ТАХ
- ✓ Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаанд 5.0 сая төгрөгийн 1 ТАХ
- ✓ Малын хөлийн албан татвараар хэрэгжүүлэх 147 ТАХ-нд 3,436.8 сая
- ✓ Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 1 төсөл арга хэмжээнд 18.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна. (Хавсралт судалгаа-9)

Дээрх тоон мэдээллээс харахад Баянхонгор аймгийн хэмжээнд 2024 онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээнээс малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 33 хувь, орчны тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 23.1 хувь, иргэдийн эрүүл мэнд, боловсрол, соёлд хөрөнгө оруулах 17.5 хувь, дэд бүтэц, зам засах, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажил 11 хувь буюу дийлэнх хэсгийг эзэлж байна. Харин иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өрхийн орлогыг дэмжих, ажлын байр бий болгох зэрэг төсөл арга хэмжээнүүд хамгийн бага хувийг эзэлж байгаа тул цаашид иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр нэмэгдэхэд чиглэсэн төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх нь чухал байна.

Түүнчлэн сумдын ИТХ-аар “тайлант онд хэрэгжүүлэх” төсөл арга хэмжээний нэршлийг тухайн жилийн төсөв батлагдахаас өмнө буруу, тодорхойгүй байдлаар батлах, улмаар жилийн явцад тодотгол хийж нэршлийг өөрчлөх, шинээр хэрэгжих болон шилжих төсөл арга хэмжээг зөрүүтэй батлах тохиолдол цөөнгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Нисэх буудлын тохижилтын ажилд 20.0 сая, Төрийн архивыг 125 нягтруулсан шүүгээгээр хангахад 60.0 сая, Зэвсэгт хүчний 103 дугаар салбарын штабын байрны засвар 20.0 сая, Ламын гэгээн Лувсанданзанжанцаны түмэн өлзий гийсний 385 жилийн ойн арга хэмжээний зардалд 150.0 сая, Төрийн албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад 220.0 сая төгрөгийг баталсан нь холбогдох хууль, журамд нийцээгүй байна.
- Бууцагаан сумын ИТХ-ын 2023 оны 13/07 дугаар тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтад “Соёлын төвийн тоног төхөөрөмж” гэж 20.0 сая төгрөг төлөвлөсөн төсөл арга хэмжээг 2024 оны ИТХ-ын төсвийн тодотгол батлах тухай 17/12 дугаар тогтоолд “Соёлын төвийн тоног төхөөрөмж түрээслэх” болгон өөрчилж “Дүүрэн тун” ХХК-тай сумын 100 жилийн үйл ажиллагаанд зориулан соёлын төвд ашиглах тоног төхөөрөмж түрээслэх гэрээ байгуулан 4 хоногийн түрээсийн төлбөрт 18.2 сая төгрөг зарцуулсан байна.

Шийдвэрлэлт: Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2, 4.3 дахь заалттай нийцэхгүй байгаа тул ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөж байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, сумдын ИТХ-д толилуулав.

Баян-Өндөр сумын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа шинээр эхлэх ТАХ-г шилжих ТАХ-ээр баталсан, Баацагаан сумын ИТХ-аар 2023 оноос шилжиж ирсэн төсөл арга хэмжээнд Иргэд олон нийтийн эрүүлжүүлэх сувилах цэг байгуулах нэрээр баталсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Баацагаан сумын Бөөнцагаан нуурт отоглох цэг байгуулсан зэрэг асуудлуудыг цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд зөвлөв.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДАД ХӨРӨНГӨ ХУДАЛДАН АВАХ, АРД ИРГЭДЭД ТУСЛАМЖ ОЛГОХОД ЗАРЦУУЛДАГ БАЙДЛЫГ ТАСЛАН ЗОГСООЖ, ОРОН НУТАГТ ҮР ӨГӨӨЖТЭЙ, БОДИТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтыг мөрдөөгүй, хариуцлагыг тооцохгүй байгаа нь ажлууд чанаргүй хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчин зохион байгуулсан байна.

Баянхонгор аймаг, сумын хэмжээнд 2024 онд нийт 20,489.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 142 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулснаас 13,580.8 сая төгрөгийн 33 /23.2%/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 6,908.2 сая төгрөгийн 109 /76.8%/ төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар шалгаруулсан байна.

Баянхонгор аймаг болон Баацагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Баянлиг сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХӨАТҮХАТ-ийн 7.1.2, 10.3, 48.5, 51.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолоор "Шаардлагатай зураг төсөв хийлгэх" арга хэмжээнд 200.0 сая төгрөгийг баталсан байхад худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, 8 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;
- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 59.7 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн тоглоомын талбайн худалдан авах ажиллагааны тендерийг шалгаруулахдаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөөгүй аж ахуйн нэгжийг шалгаруулсан;
- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 25.0 сая төгрөгийн өртөг бүхий нийтийн нойл барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт татварын өртэй "Могойн хөндий ХХК"-ийг шалгаруулсан, үнэлгээний хорооны гишүүн Д.Должинсүрэн ашиг сонирхлын зөрчилтэй мэдэгдэлд сонирхлын зөрчил үүссэн тухай мэдээллийг бүрэн бөглөөгүй, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь тус иргэнийг тендерийн үнэлгээний хуралд оролцуулаагүй байхад оролцсоноор хурлын тэмдэглэлийг хөтөлсөн;
- Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сургуулийн хичээлийн байрны засвар, сумын газар зүйн нэрийн тодруулга хийх зэрэг 2 худалдан авах ажиллагааны баримтуудыг архивын нэгж болгон байгууллагын архивд шилжүүлээгүй;
- Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр "2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв хийлгэх арга хэмжээ"-нд 70.0 сая төгрөг батлагдсан байхад худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүй "Төгс Орхон" ХХК-тай шууд гэрээ байгуулсан;
- Баянлиг сумын ИТХ-аар "Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх" ажлыг 100.0 сая төгрөгөөр баталсан байхад худалдан авах ажиллагааг 57.2 сая төгрөгөөр зарласан;
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажилд 120.0 сая төгрөг баталсан байхад худалдан авах ажиллагааг 100.0 сая төгрөгөөр зарласан;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас Эрдэнэцогт сумын ОНХС-д эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн "Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төв бүхий спорт заал" төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримтыг үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж байсан Ш.Жавхлантөгс ажил хүлээлцэхдээ тус баримтыг хүлээлцэж өгөөгүй гэх шалтгаанаар шаардсан хугацаанд баримтыг гаргаж өгөөгүй нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэл учруулсан. Мөн тус худалдан авах ажиллагааны баримтыг архивын нэгж болгон зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүй;
- Баянхонгор сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 16/96 дугаар тогтоолоор "2024, 2025 онд хийгдэх ажлуудын зураг, төсөв хийлгэх" ажлыг 50.0 сая төгрөгөөр баталсан байхад худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй буюу төсөвт өртгийг хуваан 3 өөр компанитай гэрээ байгуулсан;

- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримтаас нийт 14 ажлын хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
- Баянбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 305.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээний тендерийг 2024 онд зохион байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны баримтуудыг архивын нэгж болгон үдээгүй, байгууллагын архивд шилжүүлээгүй байна.

Сумдад худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай хүмүүсийн тоо цөөхөн, үнэлгээний хороонд ажиллаж байгаа гишүүд урамшуулал авахгүй атлаа аудитаар илэрсэн зөрчилд хариуцлага үүрэх нөхцөл байдал үүсдэг тул худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай болох хүсэлгүй, зориудаар шалгалтад тэнцдэггүй, төсөвт өртөг багатай төсөл арга хэмжээнд оролцогч аж ахуйн нэгж тендерт оролцдоггүй гэсэн тайлбарыг өгч байна.

Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай хүмүүсийн тоог тухайн жилд нэмэгдүүлэх талаар заалт оруулсан боловч тайлант оны эцэст ажил дүгнэхэд тус заалтыг дүгнэдэггүйгээс худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил буурахгүй давтагдсаар байна.

Шийдвэрлэлт: Баянхонгор аймгийн төсөвт байгууллагууд, тусгай сангуудын худалдан авах ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж, зөвлөн туслах талаар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт, Худалдан авах ажиллагааны төсөвт зардлыг төлөвлөх, АЗ сертификаттай иргэдийг урамшуулж, идэвхийг нь нэмэгдүүлэх асуудлыг аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд тусган ажиллахыг тус тус зөвлөв.

Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,181.4 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор Галуут сум 92.0 сая, Баян-Овоо сум 315.4 сая, Баянлиг сум 33.5 сая, Жаргалант сум 150.0 сая, Бөмбөгөр сум 141.9 сая, Өлзийт 120.0 сая, Баянбулаг сум 37.7 сая, Баян-Өндөр сум 117.0 сая, нийт 1,036.4 сая төгрөгийн өвс тэжээл худалдан авах зардалд баталсан төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Сангийн хөрөнгөөр өвс, тэжээлийг бэлтгэхдээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байгаа нь төсвийг хэмнэх, өрсөлдөөнийг дэмжих боломжуудыг олгохгүй байна.

Мөн дээрх зөрчлүүд нь өвөлжилт хүндэрсэн, онцгой нөхцөл байдлын үед аймгийн Засаг дарга, аймгийн онцгой байдлын комиссоос гаргасан шийдвэр нь ямар хугацаанд хэрэгжихийг зааж өгөөгүйгээс өмнөх гарсан шийдвэрийг үндэслэн өвс, тэжээлийн худалдан авах ажиллагааг шууд гэрээгээр худалдан авахад хүргэж байгаа бөгөөд сумдад өмнөх жилүүдэд худалдан авсан их хэмжээний өвсний үлдэгдэл байгаа нь цаашид чанарын шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй байдал үүсэхээр байна.

Шийдвэрлэлт: Онцгой нөхцөл байдлын улмаас өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ захирамжид өвс тэжээлийг ямар хугацаанд бэлтгэх талаар тодорхой хугацааг оруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

2.1.2. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээнд төлбөр хийх нөхцөлийг тодорхой заагаагүй, гэрээний хугацаа дууссан, ажлыг чанаргүй буюу дутуу хийсэн, зураг, төсвөөс өөрөөр хийсэн байхад захиалагч байгууллага арга хэмжээ авч ажиллаагүйгээс ажлууд чанаргүй хийгдэх, орхигдох эрсдэл дагуулж байна.

Баянхонгор аймаг, сумдын ИТХ-аар 2024 онд нийт 32,528.8 сая төгрөгийн 655 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталснаас 100 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжсэн, 555 төсөл арга хэмжээ нь шинээр батлагдсан байна. Баталсан арга

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

хэмжээнээс 15,132.6 сая төгрөгийн 116 төсөл арга хэмжээ нь огт хэрэгжээгүй бөгөөд гэрээ байгуулсан 539 төсөл арга хэмжээнээс 24,568.7 сая төгрөгийн гэрээтэй 472 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 12,294.5 сая төгрөгийн гэрээтэй 67 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд байна.

Хүснэгт 3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо, дүн (сая төг)

Аймаг, сум	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, ТАХ-ний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний		Дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээний		Огт хэрэгжээгүй төсөл арга хэмжээний	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
Аймаг	100	12,107.2	79	16,849.3	69	11,976.4	10	4,796.6	21	10,333.9
Сум	555	20,421.60	460	20,089.80	403	12,592.3	57	7,497.9	95	4,798.6
Дүн	655	32,528.8	539	36,939.10	472	24,568.7	67	12,294.5	116	15,132.5

Эх сурвалж: ТАБ-ын бэлтгэсэн судалгаа

Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 12,107.2 сая төгрөгийн 100 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 10,333.9 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнээс хандивын орлого тасарснаас 1, худалдан авах ажиллагаа хожуу зохион байгуулснаас 3, гүйцэтгэгч ажлаас татгалзсанаас 1, худалдан авах ажиллагаанд шаардлага хангасан аж ахуйн нэгж ирээгүйгээс 1, газрын асуудал маргаатайн улмаас 1, төсөл арга хэмжээний зураг, техникийн тодорхойлолтыг захиалагч байгууллага бэлтгэж ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагаа зарлаагүй 6, зураг төсөв магадлалаар орж нэмэгдсэнтэй холбоотой 1, сумдад эрх шилжүүлсэн ажлыг хэрэгжүүлээгүйгээс 2, гүйцэтгэгч гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүйгээс 5 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжээгүй байна.

Харин сумдын төлөвлөсөн арга хэмжээнээс 4,798.6 сая төгрөгийн 95 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь малын тоо толгойн албан татвар тасарснаас эх үүсвэр бүрдээгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, тендерт оролцогч ирээгүй, зураг төсөв алдаатайгаас худалдан авах ажиллагаа зарлаагүй зэргээс шалтгаалжээ.

Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад өмнөх аудитаар илэрч, Төрийн аудитын байгууллагаас зөвлөмж, албан шаардлага өгч, төлбөрийн акт тогтоож байсан дараах зөрчил дутагдлууд бүрэн арилахгүй байна. Үүнд:

- Санхүүжилтийг олгосон байхад ажлыг дутуу, чанаргүй гүйцэтгэсэн
- Санхүүжилтийг авсан атлаа ажлыг гүйцэтгээгүй
- Гэрээг дүгнэж ажлаа хүлээлгэн өгсний дараа, анхан шатны баримтыг үндэслэн санхүүжилтийг олгохоор гэрээнд заасныг баримтлаагүй
- Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй
- Захиалагчийн хяналтыг тухай бүрд хийгээгүй зэрэг байна.

Аймаг, сумын Засаг дарга, захиалагч байгууллагуудын удирдлагууд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12 дахь заалт болон гүйцэтгэгч захиалагчийн хооронд байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн:

Тогтоосон төлбөрийн акт

- Баацагаан сумын ЕБС-ийн газар зүйн кабинетыг тохижуулах ажлыг гүйцэтгэхээр Баянхонгор аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан "Далай ээж баян хонгор" ХХК гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй, 0.5 сая төгрөгийн газарзүйн сургалтын хэрэглэгдэхүүнийг хүлээлгэн өгөөгүй ба барааг хүлээн авсан комиссын актад тус хэрэглэхүүнийг хүлээн авснаар бүртгэсэн;

Өгсөн албан шаардлага

- Баянхонгор аймгийн ОНХС-аас олгосон 20.0 сая төгрөгийн 4 өрхөд олгосон гэр, 20.0 сая төгрөгийн 4x8 харьцаатай хүлэмжийг 10 өрхөд олгосон талаарх анхан шатны баримт байхгүй
- "Шуурхай удирдлагын төвийг байгуулах" ажлыг гүйцэтгэсэн "Айети юнипикэшин" ХХК нь хөргүүрийн системийг байршуулаагүй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн:

Тогтоосон төлбөрийн акт

- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөс сумын төвийн баганат талбай байгуулах ажлыг гүйцэтгэгч "Номгон Оюу" ХХК-д зураг төсвийн болон зохиогчийн хяналтын зардлын 6.1 сая төгрөгийг шилжүүлсэн;
- Баян-Овоо сумын 2023 оны санхүүгийн тайланд бүртгэсэн "Арслант хүлэг" ХХК-ийн 29.0 сая төгрөгийн авлагыг өвс, тэжээлийг хүлээн аваагүй атлаа орлогоор бүртгэж, авлагыг хаасан зөрчилд төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад орон нутгийн орлогод төвлөрүүлж зөрчлийг арилгуулсан;
- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нөөц бүрдүүлэх" арга хэмжээний хүрээнд 0.6 сая төгрөгөөр принтер худалдан авсан;
- Шинэжинст сумын Засаг даргын тамгын газрын дарга Л.Батхуяг, иргэн Л.Эрдэнэчулуун нарын хооронд 2024 оны 03 сарын 13-нд байгуулсан "Халуун усны засварын ажил хийх" БХШЖСЗДТГ/20240601015 дугаартай гэрээнд заасан захиалагчийн хяналтын зардлыг суутган тооцоогүй гүйцэтгэгч рүү 0.4 сая төгрөгийг илүү шилжүүлсэн нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 2.2-т заасан заалтад нийцээгүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн гүйцэтгэсэн "Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төвийн засвар" ажлыг гүйцэтгэгч "Хашгоёо" ХХК-д ажлын зураг төсөвт заасан захиалагчийн хяналтын зардлын 2.6 сая, зураг төсөл зохиогчийн хяналтын зардлын 1.8 сая төгрөгийг суутгаагүй тооцоогүй, илүү санхүүжилт олгосон;
- Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд Ногоон байгууламж нэмэгдүүлэх /мод тарих/ ажлын хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр "Батсү Бөх" ХХК-тай 18.0 сая төгрөгөөр модны тарьц, суулгац худалдан авах гэрээ байгуулж, 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр гэрээний урьдчилгаа санхүүжилтэд 9.0 сая төгрөгийг олгосон боловч ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгөөгүй;
- Баянлиг сумын Засаг дарга, "Буянт хөрс наран" ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 24/10 дугаар "Баянлиг сумын цагаан агуйн тохижилтыг гүйцэтгэх гэрээнд камерын бичлэгийн программ бүхий 17 инчийн I7 маркийн зөөврийн компьютерыг авахаар заасан байхад 15 маркийн үзүүлэлт өөр компьютер бэлтгэж, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй хөрөнгө бэлтгэсэн;
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Нака кацуми" ХХК сургуулийн биеийн тамирын талбайн ажлыг 39.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан, аудитын биет тулгалтаар гар бөмбөгийн талбай заасан хэмжээнээс 40.5 м2 талбай дутуу хийгдсэн байна.

Өгсөн албан шаардлага

- Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаяр, Баянхонгор сумын "Гон гандан Дэдлин хийд" нарын хооронд байгуулсан БХАБХСЗДТГ/2024035 дугаартай "Гандангийн гадна тохижилт хийх" төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа 2024 оны 06 дугаар сарын 28-нд дууссан байхад гүйцэтгэгч талаас ажлыг бүрэн дуусгасан ч тайлан ирүүлээгүй шалтгаанаар үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй, тус ажлыг хүлээн аваагүй байна;
- Баянлиг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 97.5 сая төгрөгөөр Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуйн тохижилтын ажлыг гүйцэтгэхээр Баянлиг сумын Засаг дарга "Буянт хөрс наран" ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 24/10 тоот гэрээ байгуулсан ба ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй, ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, хийгдсэн ажлууд чанаргүй, дутуу байхад захиалагч байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ аваагүй;
- Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг дарга, иргэн Б.Мөнхжаргалтай 2024 оны 06 дугаар 17-ны өдөр 2 дугаар багийн төвийн урсгал засварын ажлыг гүйцэтгэхээр 13.6 сая төгрөгийн гэрээ

байгуулж, 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүлээлгэн өгөхөөр заасан, тус гүйцэтгэгчид 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байхад ажлыг хүлээлгэн өгөөгүй;

- Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Нийтийн эзэмшлийн талбайд авто зам барих, хашлага хийх" 100.0 сая төгрөгийн гэрээг 2022 онд "Холбоогийн гурван хавцгай" ХХК-тай байгуулж, 94.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Гэрээг 2023, 2024 онд сунган ажилласан бөгөөд чанар муу хийгдсэн шалтгаанаар ажлыг хүлээж аваагүй байна;
- Гурванбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд сумын хүүхдийн тоглоомын талбай барих 71.5 сая төгрөгийн гэрээг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр "Дэлгэрэх асгат хайрхан" ХХК-тай байгуулсан. Тус ажлын зураг төсөвт тусгагдсан явган замын хашлага тавих, бетон автомашины зогсоол барих, навчит мод, зүлэг суулгах ногоон байгууламжийн ажлууд дутуу хийгдсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон;;
- Эрдэнэцогт сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан "Нийтийн биеийн тамирын орчныг сайжруулах" ажлыг 19.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр иргэн Э.Жагваралтай 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 11 дугаартай гэрээ байгуулж, 2 удаагийн шилжүүлгээр 17.9 сая төгрөгийг олгосон байхад техникийн тодорхойлолтод заасан ажлуудаас зөвхөн бохирын шугам солих ажлыг гүйцэтгэснээс өөр ажлыг гүйцэтгээгүй, нэмэлт гэрээгээр ажлыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүлээлгэн өгөхөөр заасан боловч ажлыг хүлээлгэн өгөөгүй;
- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөс 8,0 сая төгрөгийг "Буянт таван буурал" ХХК-д ариутгалын бодис, автомакс, халдваргүйтгэлийн хувцас авсан ба зарцуулалтын тайлан анхан шатны баримтад байхгүй;

Захиалагч байгууллага хуулийн байгууллагад шилжүүлсэн төсөл арга хэмжээ:

- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Буянт хөрс наран" ХХК-ийн гүйцэтгэж байгаа орон нутгийн барилгын их засварын ажлыг аймгийн ГХБХБГ-аас зогсоох албан бичгийг захиалагч байгууллагад хүргүүлсэн байхад тус компанид 38.9 сая төгрөгийг олгосон бөгөөд "Буянт хөрс наран" ХХК-тай холбоотой асуудлыг холбогдох албан тушаалтан хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд жил бүр давтагдан илэрч байгаа нь аймаг, сумын төрийн сангийн төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтнүүд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,тайлагнах журам”, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгодоггүй зөрчил сумдад нийтлэг байна.

Шийдвэрлэлт: Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10.3.3-т заасныг хэрэгжүүлж ажиллаж байгаад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг Баянхонгор аймгийн СТСХ-т зөвлөв.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөл, гүйцэтгэлийн чанар, техникийн тодорхойлолт, чанарын баталгаа, тооцох хариуцлага, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг төсвийн үнэ, зураг төсөв зохиогчийн хяналтын зардал зэргийг нарийвчлан тусгаагүй зэрэг зөрчил сумдад нийтлэг байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Жаргалант сумд цэцэрлэгийн тоглоомын талбай байгуулах, Бууцагаан сумын төрийн байгууллагуудын дунд зам хийх, нийтийн орон сууцуудын орц гарцад гэрэлтүүлэг хийх ажил, Заг сумын Эрүүл мэндийн төвийн цэвэр бохир усны шугамын ажил, ус хангамжийн эх үүсвэрийг хашаажуулах, Баян-Овоо сумын хуучин цэцэрлэгийг засварлаж ахмадын өргөө болгох зэрэг ажлуудыг гэрээнд заасан хугацаад гүйцэтгэн, хүлээлгэн өгөөгүй байхад алданги тооцоогүй;
- Баян-Өндөр сумын тендерийн баримт бичигт гүйцэтгэгчийн төлөх алдангийг заасан атлаа гэрээнд алдангийн хэмжээг өөрөөр тусгасан;

- Баацагаан сумын Соёлын төвийн лед дэлгэц нийлүүлэх гэрээнд санхүүжилтийн 60 хувийг урьдчилан олгож, ажлыг хүлээн авсны дараа 40 хувийг олгохоор заасан байхад ажил хүлээлцээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- Эрдэнэцогт сумын Засаг даргын 2023 онд байгуулсан "Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төвийн засвар", 2024 онд байгуулсан "Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төв бүхий спорт заал" барих ажлын гэрээнд захиалагчийн хяналтын зардал, зураг төсөв зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сан зэрэг суутгалыг тусгаагүй байна.
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Сү Чо Ба Даймонд" ХХК Биеийн тамирын талбайг тохижуулах ажлыг 57.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ажил 2025 оны 4 дүгээр сард хүчтэй шороон шуурга болсны улмаас тус бүтээн байгуулалт ашиглах боломжгүйгээр эвдэрсэн байгаа бөгөөд тус ажлыг ямар хугацаанд хариуцах талаар гэрээнд заагаагүй байна.

Шийдвэрлэлт: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас аймаг, сумдын Засаг дарга нарт орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулах ажил гүйцэтгэх гэрээнд заавал тусгавал зохих санамжийг боловсруулан, тайлангийн хавсралтаар хүргүүлж, аудитын тайлангаар гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээнд заасан алдангийг тооцох хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил, төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, хянуулаагүйгээс захиалагч болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд төсөл арга хэмжээг дур мэдэн өөрчлөн хийх, техникийн тодорхойлолтод тусгасан боловч хийгээгүй ажлын оронд өөр ажил гүйцэтгэсэн гэх боловч тооцоо, судалгаа байхгүй, техникийн тодорхойлолтод өөрчлөлт хийх, хийсэн тухай нотлох баримтууд байхгүй байгаа ба энэ нь аудитаар тулган шалгахад хүндрэл учруулж байна.

Аудитын илрүүлэлт:

- Баян-Өндөр сумын Засаг дарга, "Твин фалкон" ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулж, сумын Соёлын төвд нийлүүлэх барааны жагсаалтад үзмэрийн шилэн хормо 1.5 метр өндөртэй байхаар боловсруулсан нь хүүхэд багачуудын өндөрт тохируулан боловсруулаагүй;
- Баянлиг сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Мандалтурс Монголиа" ХХК Нийтийн биеийн тамир хөгжүүлэх бараа нийлүүлэх гэрээнд заасан хивс хэмжээндээ хүрээгүй, барианы газар шинэчлэх ажлыг гүйцэтгээгүй, түүний оронд гарааны төхөөрөмж хийлгэсэн;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Номундалай цогцолбор сургуулийн спортын талбай байгуулах ажлын техникийн даалгаварт Модон сүүдрэвч хийхээр, зураг төсөвт төмөр сүүдрэвч хийхээр заасан нь зөрүүтэй;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн "Гэгээншавь 6-р багийн төвийн гадна тохижилт хийх" ажлын хүрээнд "Жарганатайн хөх тариа" ХХК-тай байгуулсан гэрээний техникийн тодорхойлолтод төвийн бохирын шугамд холбох 80 метрийн ажил хийгдэхээр заасан боловч тус ажлыг гүйцэтгэхэд бохирын шугамын ажлыг нийтэд нь солих шаардлагатай болсон тул тус ажил хийгдээгүй;
- Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Эрүүл мэндийн төвийн гадна дотоод тохижилт" төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулсан албан тушаалтны гарын үсэг байхгүй, тоног төхөөрөмжийн хүчин чадал, маркийг тодорхой заагаагүй байна.

Шийдвэрлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх тусгай мэргэжил шаардсан төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг аймгийн холбогдох мэргэжлийн агентлагаар хийлгэх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн даргад өмнөх жил өгсөн боловч хэрэгжүүлээгүй тул тус зөрчилд албан шаардлагыг хүргүүлэв.

Сумдын Засаг дарга нарт төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар зөвлөмж өгсөн тул хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

2.2. Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрсэн байна.

2.2.1. Баянхонгор аймгийн хэмжээнд 2024 онд бүрэн хэрэгжүүлсэн 11,976.4 сая төгрөгийн 69, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн 12,592.3 сая төгрөгийн 403 төсөл арга хэмжээнүүд зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн байна.

2.2.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг шат, шатны ИТХ-аар батлахдаа хэт жижиглэсэн байгаа нь орон нутагт томоохон хөрөнгө оруулалтын ажил хийгдэх, ажлын байр нэмэгдэх боломжийг алдсаар байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2024 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 472 төсөл арга хэмжээнд 24,568.7 сая төгрөгийг зарцуулснаас 52.9 хувь буюу 13,003.3 сая төгрөг нь үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж бэлтгэх, засварлахад, 26.2 хувь буюу 6,425.5 сая төгрөг нь иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлэхэд, 20.9 хувь буюу 5,139.8 сая төгрөг нь урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээнд зарцуулжээ.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөс ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээнд өмнөх онд 1,099.9 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол 2024 онд 188.9 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь өмнөх оноос буурсан бөгөөд сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн үр өгөөжийг нэгтгэж тооцож гаргасан мэдээллийг аудитын багт ирүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд аймаг, сумд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний сайн жишээ:

Баянхонгор аймаг:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эмнэлгийг 1,104.7 сая төгрөгөөр барьж гүйцэтгэн, ашигласан.
- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр 172.9 сая, “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслөөс 102.2 сая, нийт 275.1 сая төгрөгийн санхүүжилтээр “Байгалийн сэргэн ургалтыг дэмжих зорилгоор “Заган ойг” хашиж хамгаалах ажлыг Зармангийн говийн бүсэд хамаарах Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дэвсгэрт 300 га талбайг 2 дугаар багийн 4 цэгт хашиж, заган ойн сэргэн ургалтыг дэмжих ажил хийж, мэргэжлийн байгууллагуудын оролцуулан хүлээн авсан байна.
- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 527.5 сая төгрөгийн өртөг бүхий эмгэг судлалын барилгыг барьж ашиглалтад оруулсан.

Баянхонгор сум:

- ✓ Баянхонгор сумын ОНХС-ийн санхүүжилтээр Цагаанчулуут 5 дугаар багийн Ахмад настнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулснаар иргэд чөлөөт цагийг өнгөрүүлэх, байгальд тухлан амрах боломжийг бүрдүүлсэн.

Шинэжинст сум:

- ✓ Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөс өмнөх оноос хэрэгжсэн, 1,367.8 сая төгрөгийн өртөг бүхий биеийн тамирын гадаа талбай байгуулах /спорт цэцэрлэгт хүрээлэн/ ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн томоохон ажлуудыг нэг бөгөөд тус цэцэрлэгт хүрээлэн ашиглалтад орсноор иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх боломжийг олгосон;

Бууцагаан сум:

- ✓ Бууцагаан сумын ОНХС-ийн санхүүжилтээр 40.0 сая, Баянхонгор аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр 86.0 сая төгрөг, нийт 126.0 сая төгрөгөөр Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгууд руу зорчих улсын чанартай авто зам дагуух нийтийн ОО, душийг байгуулж, хүлээн авч ашигласан;

Баацагаан сум:

- ✓ Баацагаан сумын ОНХС-ийн санхүүжилтээр 25.0 сая төгрөгөөр сумын төвд нийтийн боловсон ОО хийж ашиглаж байгаа зэрэг сумд хэрэгжсэн сайн жишээ болж байна.

Аудитын явцад Баянхонгор аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд бүрэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чанарыг ашиглагч байгууллагын болон аудитын баг үнэлэхэд 90.3 хувийг сайн, 8.5 хувийг дунд, 1.3 хувийг хангалтгүй гэж үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн 1963 иргэдээс авсан санал асуулгын дүнгээр ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний чанарыг 47.1 хувь нь Сайн, 40.4 хувь нь Дунд, 14.0 хувь нь Хангалтгүй гэж үнэлсэн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон атлаа гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй, хийгдсэн ажлууд дутуу, чанаргүй хийгдсэн, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу ажлуудыг хийгээгүй, хөрөнгийг ашиглаж эхлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Тогтоосон төлбөрийн акт

- Баян-Өндөр сумын Засаг дарга, "Динамик лайн" ХХК-ний захирал нарын хооронд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан "Сумын төвийн камержуулалт" ажлын гэрээнд хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлд нийт 11.9 сая төгрөгийн дрон, нарны толь, бусад тоног төхөөрөмжийг олгосон;

Өгсөн албан шаардлага

- Баянлиг сумын Засаг дарга "Түйн голын төгөл" ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулж, 20.0 сая төгрөгөөр 400 метр хайс хийж, 400 ширхэг мод тарих ажлыг гүйцэтгэсэн, аудитаар биет тооллого хийхэд 143 ширхэг мод ургаагүй;
- Шинэжинст сумын биеийн тамирын гадаа талбай байгуулах нэрээр батлагдсан "Элбэг констракшн" ХХК-ийн гүйцэтгэсэн "Шинэжинст сумын биеийн тамирын гадаа талбай байгуулах" ажлын төсөвт тусгасан нарс мод тариагүйд;
- Хуучнаар Жаргалан паркийн газар шорооны ажил болон төв хаалганы төмөр бетон хийцийг гүйцэтгэхэд 2023 онд Баянхонгор аймгийн ОНХС-аас 174.0 сая төгрөгийг олгохоор баталсан ба аймгийн Засаг дарга, ХОБХТХ-ийн дарга, мэргэжилтэн, ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга, зураг төсөв зохиогч болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн дарга нар 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, дээрх төсөл арга хэмжээнд батлагдсан санхүүжилтийг Оготнотой булагт хүүхдийн тоглоомын цогцолбор байгуулахад зарцуулах шийдвэрийг гаргасан ба ажил гүйцэтгэх гэрээг шинэчлэн байгуулаагүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Шуурхай удирдлагын төв"-ийг байгуулсан боловч тус дэд төвд эмнэлэг, онцгой байдлын газрын албан хаагчид ажиллаагүй бүрэн ашиглаагүй байгаа;
- Баянхонгор аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн "Баянхонгор сумын ус хангамжийн эх үүсвэрийг хашаажуулах" төсөл арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна.
- Богд сумын ИТХ-аар баталсан "Эмнэлгийн гадна хашааг шинэчлэх" ажлын хүрээнд Засаг дарга Л.Ганаа, "Цастын салхи ХХК" нарын хооронд 30.0 сая төгрөгийн гэрээ байгуулж гэрээний 3.2-т заасны дагуу урьдчилгаа төлбөрт 60 хувийн санхүүжилтэд 18.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба гэрээний хугацаа 2024 оны 07 дугаар сарын 01-нд дууссан байхад гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, ажлыг хүлээлгэж өгөөгүй;
- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Жижиг хөх толгойн тохижилт хийх" ажлын хүрээнд "Далай ээж Баянхонгор" ХХК-тай байгуулсан гэрээний техникийн тодорхойлолтод заасан ажлуудаас түшлэгтэй модон сандал 1 ширхэг, сүүдрэвч хооронд холбосон явган хүний зам хийх зэрэг ажлууд хийгдээгүй байхад хүлээн авсан;
- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Нийтийн эзэмшлийн талбайн самбарын засвар" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод заасан 1 ширхэг гурван бүс цогцолбор байршлын самбар, 1 ширхэг мазаалай паркийн байршлын самбарыг хийгээгүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн "Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төв бүхий спорт заал" төсөл арга хэмжээний хүрээнд "Хашгоёо ХХК"-тай байгуулсан гэрээний хугацаа 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр дууссан байхад гүйцэтгэгч ажлыг хүлээлгэн өгөөгүй байна.
- Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаяр, "Би Би Ди Эм ХХК"-ий хооронд байгуулсан "3 дугаар багийн тоглоомын талбайн засвар" төсөл, арга хэмжээний гэрээний сунгалтын хугацаа 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр дууссан байхад уг ажлыг бүрэн хийж хүлээлгэж өгөөгүй;
- Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаяр, "Чандмань Баянхонгор ХХК" нарын хооронд байгуулсан "3 дугаар багийн усан сан ухаалаг болгох" төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа 2024 оны 10

дугаар сарын 25-ны өдөр дууссан байхад уг ажлыг бүрэн хийж хүлээлгэж өгөөгүй, ажлын даалгаварт заасан ус түгээх автомашины зогсоолыг хийгээгүй;

- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн хийгдсэн "6 дугаар багийн шаардлагатай өрхүүдэд гэр олгох" ажлыг "Ээлгеранд" ХХК 109.5 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэсэн ба гэрээний 2.2-т заасны дагуу урьдчилгаа санхүүжилт 30 хувийг гүйцэтгэгчид шилжүүлэн ажлын даалгаварт заасан 22 ширхэг 5 ханатай гэр хүлээн авахаас 15 ширхгийг хүлээн авч, 6-р багийн айл өрхүүдэд ирүүлсэн өргөөдлийг үндэслэн олгосон, тус гэрээний хугацаа 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдөр дууссан байхад нийлүүлэгч үлдсэн 7 ширхэг гэрийг хүлээлгэн өгөөгүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн хийгдсэн "Шаардлагатай цэгүүдэд тоглоомын талбай барих" ажлын хүрээнд БХАХААГ/20240101030 дугаартай 4 багц бүхий худалдан авах ажиллагаа зарласнаас 1,2,4 дүгээр багцад "Ерөөл нэмэх" ХХК шалгарсны дагуу багц-1 Дуурсах 3-р багийн тоглоомын талбай байгуулах ажилд 134.3 сая, багц-2 Гэгээншавь 6-р багийн тоглоомын талбай байгуулах ажилд 116.2 сая, багц-4 Номгон 1-р багийн тоглоомын талбайн тохижилт, авто зам байгуулах ажилд 144.2 сая төгрөгийн санхүүжилтийг авахаар гэрээ байгуулж, гэрээний хугацааг 2025 оны 06 дугаар сарын 01-ны өдөр хүртэл сунгасан дууссан байхад гүйцэтгэгч компани ажлаа хүлээлгэн өгөөгүй;
- Баянбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр ундны эх үүсвэрийн усан сан байгуулах ажлын хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр "Елбата" ХХК-тай 09 тоот бүхий 173.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, ажлын урьдчилгаанд 61.2 сая төгрөг олгосон бөгөөд гэрээний хугацаа 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр дууссан байхад уг ажлыг бүрэн хийж хүлээлгэж өгөөгүй;
- Гурванбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр Ундны эх үүсвэрийн усан сан байгуулах ажлыг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 167.6 сая төгрөгөөр "Галгэрэл констракшин" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 130.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон, гэрээний хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр дууссан байхад уг ажил хийгдэж дуусаагүй;
- Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Нийтийн эзэмшлийн талбайд авто зам барих, хашлага хийх" 100.0 сая төгрөгийн гэрээг 2022 онд "Холбоогийн гурван хавцгай" ХХК-тай байгуулж, 94.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Гэрээг 2023, 2024 онд сунган ажилласан бөгөөд чанар муу хийгдсэн шалтгаанаар ажлыг хүлээж аваагүй байна;
- Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Даяар трейд" ХХК-тай Сургуулийн дотуур байрны засварын ажил гүйцэтгэх 100.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн 2024 оны 07 дугаар сарын 25-нд сумаас ажлын хэсэг томилогдон ажлыг хүлээн авсан байна. Тус ажлын зураг төсөв алдаатай төлөвлөгдсөн байхад ИТХ-аар батлуулан, захиалагч гүйцэтгэгч талууд хоорондоо зөвшилцөн ажлыг хийсэн ба чанаргүй, дутуу ажил хүлээн авсан;
- Өлзийт сумд Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн "04 шугамын өргөтгөл хийх" ажлын хүрээнд "Алтанзавьяа Ундарга" ХХК-тай байгуулсан 20 дугаартай гэрээний хугацаа 2025 оны 04 сарын 15-нд дууссан байхад гүйцэтгэгч компани ажлыг бүрэн дуусгаагүй, хүлээлгэж өгөөгүй;
- Хүрээмарал сумд Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгө, Хүрээмарал сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 90 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна фасад засвар болон гадна тохижилтын ажлыг хийлгэхээр 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр "Густокек" ХХК-тай 85.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацааны дотор 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр сумаас томилогдсон ажлын хэсэг хүлээн авсан байна. Ажлын хэсэгт мэргэжлийн хүн байгаагүйн улмаас чанаргүй ажил хүлээн авсан;
- "Шинэжинст сумын Залаажинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулах" ажлыг иргэдээс санал аваагүй байхад баталж, "Залаа зөвлөл- НҮТББ гүйцэтгэсэн бөгөөд судалгааг 2010-2021 оны мэдээллийг ашигласан нь 2022-2023 оны мэдээллийг хамруулаагүй, судалгааны үр дүнд ямар санаа санал дэвшүүлсэн, түүнийг хэрэгжүүлж үр дүнг гаргасан эсэх нь тодорхойгүй байна.
- Баян-Өндөр сумын Засаг дарга, "Ган утас мөнх" ХХК-ийн удирдлагууд "Баян-Өндөр сумын 0.4кВ-ын шугамын өргөтгөл, засварын шинэчлэл"-ийн ажлыг 85.1 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр байгуулж, ажлыг гүйцэтгэсэн, ажлыг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг хүлээн авсан боловч тус шугамын өргөтгөл айлын хашаа хоорондын зай холбогдох журам, стандартад заасан хэмжээнээс ойр байгаа, газрын зөвшөөрөлгүй баригдсан;

Баянхонгор сумын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 3/240 дугаар албан тоотоор "ОНХС-ийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын тайланд ирүүлсэн саналыг үндэслэн дараах зөрчлийг аудитын явцад арилгаав.

- Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаяр, "Үлэмж жигүүрлэгч" ХХК-ийн хооронд байгуулсан БХАБХСДТГ/2024048 дугаартай "Ёотон цагааны талбайг тохижуулах" ажлын гэрээний сунгалтын хугацаа 2025 оны 05 дугаар сарын 10-нд дууссан боловч ажлыг бүрэн дуусгаагүй, захиалагч талд хүлээлгэж өгөөгүй

- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "2024, 2025 онд хийгдэх ажлуудын зураг, төсөв хийлгэх" ажлын хүрээнд "Гео урбан консалтинг" ХХК-тай байгуулсан гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөрт 4.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс зураг төсвийг одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй

Дээрх зөрчлүүдийн улмаас төсөл арга хэмжээ он дамжин удааширснаар олон нийтийн үр өгөөж хүртэх хугацаа хойшлох, ажил хийгдэхгүй орхигдох, чанаргүй хийгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэхээр байна.

Шийдвэрлэлт: Аудитаар илэрсэн 2,580.7 сая төгрөгийн 23 зөрчлөөс 11.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,515.0 сая төгрөгийн зөрчилд 20 албан шаардлага өгч, аймгийн Засаг даргад 1 зөвлөмжийг хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор эко хавтангаар орчны тохижилт хийх ажлыг иргэдийн бүлгээр хийлгэж байгаа бөгөөд тус эко хавтанг мэргэжлийн байгууллагын лабораториор дүгнэлт гаргуулж ажиллуулаагүй байгаад холбогдох арга хэмжээг авч ажиллахыг зөвлөв.

2.3. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг төсөвт байгууллагууд бүрэн ашиглаагүй, нийтийн эзэмшлийн талбайд бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүйгээс хөрөнгийн үр нөлөө гараагүй байна.

2.3.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр тавилга, тоног төхөөрөмж худалдан авахаас өмнө түүнийг байршуулах талбай, ажиллуулах боловсон хүчнийг бэлтгээгүй байхдаа хөрөнгийг урьдчилж бэлтгэснээс шалтгаалж, сангийн хөрөнгөөр бий болсон 540.3 сая төгрөгийн 18 нэр төрлийн хөрөнгийг аудитын биет тулгалт хийх явцад ашиглаагүй байна.

Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2, Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1, Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1, Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 6, Баянлиг сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1, Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2, Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2, Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1, Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Эрдэнэцогт суманд бэлтгэсэн 1, Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1 хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Өгсөн албан шаардлага

- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр Шинэ суурьшлын бүсэд 20.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн худаг, 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр 50.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн Эко-Баянхонгор хог ангилах цэгийг ашиглаагүй;
- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилт хийх" ажлын хүрээнд "Сү Чо Ба Даймонд" ХХК-тай байгуулсан гэрээгээр худалдан авсан нийт 17 нэр төрлийн тоглоом, тохижилтын хэрэгслээс сандал, хүүхдийн дасгалын төхөөрөмж, хөл бөмбөгийн хаалга зэрэг хөрөнгүүдийг ашиглаагүй, цэцэрлэгийн эрхлэгчийн арын өрөөнд хураалттай;
- Баян-Өндөр сумын Засаг дарга, "Буянт хөрс наран" ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулж, сумын хогийн цэг хумих, 50 ковш нийлүүлэхээр 174.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, хүлээн авсан актыг үйлдээгүй, хөрөнгийг 2025 онд хүлээн авсан атлаа гэрчилгээг сумын ЗДТГ-т шилжүүлж аваагүй;
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс "Ариун мед трейд" ХХК-аас нийлүүлсэн 40.6 сая төгрөгийн өртөг бүхий 4 төрлийн шүдний тоног төхөөрөмж, "Өнө дэлгэрэх үрс" ХХК-аас нийлүүлсэн 29.3 сая төгрөгийн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, Баянговь сумын иргэн Б.Түвшинтулгын нийлүүлсэн 17.0 сая төгрөгийн хоёрдогч түүхий эд пресслэгч машиныг ашиглаагүй байна.

- Баянлиг сумын Засаг дарга, "Батбүрэн хаан" ХХ" нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан "Хүүхдийн цэцэрлэгт хөгжмийн иж бүрэн хэрэгсэл нийлүүлэх" төсөл арга хэмжээний ажлыг шалгахад 1.5 сая төгрөгийн даралтат хөгжмийг нийлүүлээгүй, нийлүүлсэн зарим тоглоомыг дуу хөгжмийн багш байхгүй гэсэн шалтгаанаар ашиглаагүй байна.
- Бөмбөгөр сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 19.6 сая төгрөгийн Хуванцар сав ангилах, пресслэх машин 2024 оны 06 дугаар сарын 05-нд хүлээн авсан, 115.0 сая төгрөгийн Жижиг дунд үйлдвэрлэлийн байрыг 2024 оны 05 дугаар сарын 30-нд хүлээн авсан. Өнөөдрийг хүртэл зориулалтын дагуу ашиглаагүй, ЖДҮ-ийн байртай холбоотойгоор ЗДТГ-аас урсгал зардалд нийт 3.6 сая төгрөг зарцуулсан;
- Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Эрүүл мэндийн төвийн гадна дотоод тохижилт" төсөл арга хэмжээний хүрээнд сумын Засаг дарга "Медикал Ресурс" ХХК-тай байгуулсан гэрээгээр нийлүүлсэн 179.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс 6.8 сая төгрөгийн энергийн сувгийг нээх эмчилгээний массажны аппаратыг ашиглаагүй ;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Залуучуудын хөгжлийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж авах" ажлын хүрээнд "Хашгоёо" ХХК-тай байгуулсан гэрээгээр худалдан авсан нийт 40.0 сая төгрөгийн нарны үүсгүүр, түүний дагалдах хэрэгслүүдийг ашиглаагүй, Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын агуулахад хураалттай;
- Бууцагаан сумын Баянбүрдийн спорт заал бүхий барилга дотор сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 16.8 сая төгрөгийн халуун усны өрөө бий болгох ажлыг хийсэн боловч хүлээж аваагүй, ашиглалтгүй байна.
- Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд "Өвөлжөө хаваржаа ариутгах төсөл арга хэмжээ"-ний хүрээнд худалдан авсан 3.6 сая төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, "Малын үүлдэр угсааг сайжруулах" ажлын хүрээнд худалдан авсан 4.9 сая төгрөгийн 1300 ширхэг малын эмгийг ашиглаагүй байна.

Шийдвэрлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 540.3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг ард иргэд хүртэх боломжийг олгож, хөрөнгийн үр дүнг сайжруулах албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

2.3.2. Баянхонгор аймгийн Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 онд хэрэгжүүлсэн 40.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн 2 төсөл арга хэмжээний хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс үр ашгаа өгөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх оноос шилжиж ирсэн Баацагаан сумын Бөөнцагаан нуурт хийсэн отоглох цэгийг 2023-2024 онд 20.0 сая төгрөгийг олгож хийсэн ба орон нутгаас хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс анхны хүлээн авсан хөрөнгүүд эвдэрсэн, алга болсноос цаашид дахин хөрөнгө зарцуулах эрсдэлтэй;
- Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр ард иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх, хууль тогтоомж сурталчлах байгалийн үзэсгэлэнт газар, ховор ан амьтныг таниулах хамгаалах гэрэлт самбарыг 4 ширхгийг 4 байршилд суурилуулан, хүлээлгэн өгсөн боловч хадгалалт хамгаалалтгүйгээс зургууд урагдаж, самбаруудыг ЗДТГ-ын агуулахад хадгалсан;

Шийдвэрлэлт: Цаашид нийтийн эзэмшлийн талбайд байршуулах хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын асуудлыг урьдчилан шийдвэрлэж, хөрөнгийн ашиглалтад орон нутгаас хяналт тавьж, ашиглалтгүй хөрөнгийг ашиглан сангийн хөрөнгийн үр ашгийн дээшлүүлэх албан шаардлагыг Баацагаан сумын Засаг даргад хүргүүлэв.

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗДТГ-УУД ХЯНАЛТ ТАВЬЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 76.2 хувьд аймаг, сумын ИТХ, 97.4 хувьд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, 92.0 хувьд нь захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Аймаг, сумын ИТХ, СХДАГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Баянхонгор аймгийн 12 сумын ИТХ-ын хяналтын хорооноос 2024 онд хэрэгжүүлсэн нийт 539 төсөл арга хэмжээний 23.7 хувь буюу 128 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумдын ИТХ-аар хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулаагүй;
- Эрдэнэцогт, Бууцагаан, Баян-Өндөр, Галуут, Баянбулаг, Хүрээмарал, Богд, Баян-Овоо сумдын ИТХ-ын хяналтын хороо ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд 2024 онд хяналт тавьж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 онд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сумдын ИТХ-д хүргүүлж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгсөн байхад хэрэгжилт хангалтгүй тул сумдын ИТХ-д албан шаардлагыг хүргүүлэв.

Харин Баянхонгор аймгийн ИТХ нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулаагүйгээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэлт: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2 дахь, 9.4¹⁸ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар асуудлыг аймгийн ИТХ-д толилуулав.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 539 төсөл арга хэмжээнээс зөвхөн өвс, тэжээл худалдан авах төсөл арга хэмжээнд хяналт тавьсан байна.

Баянхонгор аймгийн СХДАГ нь 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймаг болон Баянлиг, Хүрээмарал, Баянговь, Жинст, Баян-Овоо, Бөмбөгөр, Жаргалант зэрэг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн өвс, тэжээлийн нөөц бэлтгэсэн байдалд хяналт шалгалт хийж, шалгалтаар 196.5 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 155.6 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгч, 40.9 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч ажилласан, шийдвэрийн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2¹⁹ дахь, 9.4²⁰ дэх, заалтыг зөрчсөн тул Баянхонгор аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны ИТХ-ын хяналтын хороод хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

¹⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

¹⁹ Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

²⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Шийдвэрлэлт: СХДАГ нь Баянхонгор аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлээгүй тул хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Толилуулах асуудал: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, сумын ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд тооцох хариуцлагын талаар заалт байхгүйгээс жил бүр аудитаар илрэх зөрчлийн тоо буурахгүй байгаа тул тус асуудлыг ЯАГ-аар дамжуулан Сангийн яаманд толилуулахаар хүргүүлэв.

3.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Захиалагч талаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөж, хөрөнгийг бий болсны дараах санхүү, хүний нөөц, тогтмол зардлыг бодитой тооцоолоогүй, гүйцэтгэгч талууд төсөл арга хэмжээг чанаргүй, дутуу гүйцэтгэснээс болж зарим хөрөнгө ашиглалтгүй байна.

Аудитаар авсан судалгаагаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн 24,568.7 сая төгрөгийн гэрээний үнэтэй 472 төсөл арга хэмжээнээс 8.5 хувь буюу 32 төсөл арга хэмжээнд, дутуу хэрэгжсэн 67 төсөл арга хэмжээнээс 1,759.1 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 5. Захиалагчийн хяналтын судалгаа

№	Аймаг, сумын нэр	Төсөл арга хэмжээний тоо					Хяналт хэрэгжүүлсэн ТАХ-ний нэр
		ГХБХБГ	ХБТХОХ	Байгаль орчны газар	ЗДТГ өөрөө	нийт	
1	Баянхонгор аймаг	8	8			16	Барилга, байгууламжийн засвар, Хүүхдийн тоглоомын талбай
2	Баянхонгор сум			1		1	Ногоон байгууламж нэмэгдүүлэх
3	Баян-өндөр сум	2	1			3	Барилга, байгууламжийн засвар, дулааны шугам сүлжээ шинэчлэх
4	Баянцагаан сум	1	1			2	Спорт заалны их засвар
5	Шинэжинст сум	1	1		9	11	Өвс, тэжээлийн нөөц, барилгын засвар, тохижилт, бэлчээрийн усан хангамж, Малчдад зориулсан сургалт
6	Хүрээмарал сум	1	1			2	Цэцэрлэгийн барилгын гадна засвар
7	Өлзийт сум				3	3	Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, замын засвар
8	Бөмбөгөр сум				2	2	Тоглоомын талбай, сургуулийн чөлөөт бөхийн дэвжээ
9	Баянбулаг сум				1	1	Орчны тохижилт
10	Жаргалант сум				2	2	Хогийн бункер нойл байгуулах, сургуулийн камержуулалт
	Нийт дүн	13	12	1	17	43	

Эх сурвалж: Аймаг, сумдын ЗДТГ болон холбогдох газруудаас ирүүлсэн тайлан, дүгнэлт

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-ын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дэд бүтэц барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны газрын байцаагч, сумдын ЗДТГ-аас томилогдсон хяналт, шинжилгээ үнэлгээний ажлын хэсгийнхэн хийж холбогдох зөвлөмж, дүгнэлт, тайланг бичсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 11 сум захиалагчийн хяналтыг хийгээгүй;
- Баянхонгор аймаг сумдад эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.3²¹ дах, 3.4.3²² дах, 9.5²³ дах заалтыг зөрчиж, Баянхонгор аймаг, сумдын Засаг дарга нар хууль, журамд заасан хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэлт: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 оны 1/40 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сумдын ЗДТГ-д хүргүүлж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгсөн байхад хэрэгжилт хангалтгүй тул сумдын Засаг дарга нарт албан шаардлагыг хүргүүлэв.

Баянхонгор аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, зохион байгуулах ажлыг БОНХОБТХ-т зөвлөмж хүргүүлэв.

Сумдад хийгдэх зураг, төсөвтэй хөрөнгө оруулалтын ажлын тоо өмнөх жилээс нэмэгдсэн, захиалагчийн хяналтыг хийгээгүйгээс зураг төсвийг дур мэдэн өөрчлөн хийх, чанаргүй хийгдэх, мэргэжлийн бус хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг хүлээн авснаар иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, ажлыг чанаргүй хийх, хийхгүй орхигдуулснаас төсөвт хохирол учрах зэрэг сөрөг үр дагавар цаашид үүсэхээр байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг дарга, “Плутус Велт” ХХК-тай байгуулсан 819.4 сая төгрөгийн гэрээгээр гүйцэтгэсэн Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлыг аудитаар тулгалт хийхэд өрөөнүүдээс бохир үнэртэж байсан, барилгын гадна талын эмульс хуурч унасан, барилгын зураг төсөвт заагдсан зарлан мэдээлэх систем, галын кран, ногоон байгууламж, түшлэгтэй 3 сандал, модон саравч 2 ширхгийг хийж гүйцэтгээгүй;
- Баян-Өндөр сумын Засаг дарга, “Буянт хөрс наран” ХХК-тай 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр “Баян-Өндөр сумын 320 хүүхдийн хичээлийн байрны анги танхим, дотоод засвар шинэчлэлийг гүйцэтгэх гэрээ” байгуулж, 664.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэсэн, гүйцэтгэлд аймгийн ГХБХБГ-т 11.0 сая төгрөгийг шилжүүлж, хяналтыг хийлгэж, хүлээн авсан байхад боржин чулуун хавтан дэвсэж шал хийх, модон хаалга /ислэг хавтангаар хийсэн/, хаалганд автомат цоож суулгах, хуванцар рамтай вакум цонх угсрах, цонхонд өнгөлсөн гантиг тавиур суулгах, цагаан төмөр хаяавч хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээгүй;
- Баянлиг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 97.5 сая төгрөгөөр Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуйн тохижилтын ажлыг гүйцэтгэхээр Баянлиг сумын Засаг дарга “Буянт хөрс наран” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 24/10 тоот гэрээ байгуулсан ба ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй, ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, хийгдсэн ажлууд чанаргүй, дутуу байхад захиалагч байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ аваагүй;
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Сү Чо Ба Даймонд” ХХК Биеийн тамирын талбайг тохижуулах ажлыг 57.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ажил 2025 оны 4 дүгээр сард хүчтэй шороон шуурга болсны улмаас тус бүтээн байгуулалт ашиглах боломжгүйгээр эвдэрсэн байгаа бөгөөд тус ажлыг ямар хугацаанд хариуцах талаар гэрээнд заагаагүй;
- Баянговь сумын спорт заалны барилгыг Шинэжинст сумын спорт заалны барилгын ажлын зургаар хийсэн;

²¹ ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

²² Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

²³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

- Баян-Овоо сумын орон нутгийн барилгын их засварын ажлыг “Буянт хөрс наран” ХХК гүйцэтгэхээр 2023.07.25-ны өдөр гэрээ байгуулсан, ажлыг гүйцэтгэх явцад зураг төсвийг “Төгс орхон” ХХК-аар 3 удаа өөрчлөлт оруулсан байхад цахилгаан болон холбооны техникийн нөхцөлийг аваагүй, захиалагчаас архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргаж өгөөгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх зөрчилд барилгын хяналтын улсын байцаагчаар хяналт хийлгэж, гаргасан зөрчилд шийтгэвэр тогтоолгож, гүйцэтгэгч компаниар чанаргүй хийсэн ажлыг давтан хийлгэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр ард иргэд, хүүхэд багачуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх тоглоомын талбай, биеийн тамирын талбай барих 3,049.2 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр тоглоомын талбайн аюулгүй байдалд холбогдох стандартуудад нийцэж байгаа талаар мэргэжлийн байгууллага хяналтыг хийгээгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх асуудалд шат шатны ИТХ, Засаг дарга, мэргэжлийн байгууллагууд анхаарлаа хандуулах нь зүйтэй тул Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын даргад 2024 онд хэрэгжүүлсэн хүүхдийн эргэн тойрны орчны бүсэд хийгдсэн ажлуудад хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, цаашид хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн суурилуулсан камержуулалт цахилгааны хэлбэлзлээс шалтгаалан шатсан, анх хүлээн авахад ажиллаж байсан гэх боловч аудитын багийн биет шалгалтаар ажиллахгүй болсон, камержуулалтыг дутуу угсарсан зэрэг 6 зөрчил илэрсэн тул Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас тайлбар авахаар албан бичгийг, хавсралтын хамт хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн хийгдсэн “Баянхонгор сумын нийтийн орон сууцуудын орц, гарцыг камержуулах, тохижилт, гэрэлтүүлэг хийх” ажлын хүрээнд БХАХААГ/20240101030 дугаартай 260.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 багц худалдан авах ажиллагааг зарлаж, багц 2-т 76.8 сая төгрөгөөр камержуулалтын ажлыг гүйцэтгэсэн “Айти юнипикейшн” ХХК ажлын даалгаварт заасан нийт 38 ширхэг камераас аймгийн нэгдсэн удирдлагын төвд 2 камерыг шон суулгаагүй шалтгаанаар холбоогүй;
- Баян-Өндөр сумын Засаг дарга, “Динамик лайн” ХХК-ний захирал нарын хооронд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан “Сумын төвийн камержуулалт” ажлын гэрээгээр 23.6 сая төгрөгийн сумын төвийн камержуулалтын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан байхад аудитын шалгалт хийх өдрөөр тог хэлбэлзсэн шалтгаанаар ашиглаагүй, цагдаагийн байр эзгүйгээс үзэх боломжгүй байсан;
- Баянговь сумын Засаг дарга, “Сүүхүнгий” ХХК-ийн захирал нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан камерын өргөтгөл, засварын ажил гүйцэтгэх гэрээнд ажлыг 47.8 сая төгрөгөөр 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авахаар гэрээнд заасан ба хүлээн авсан акт байхгүй, аудитын тулгалтаар 15 камераас 4 камер ажиллаж, 11 камер ашиглалтгүй байна. Тус ажлыг хүлээн авснаас 7 хоногийн дараа камерууд ажиллагаагүй болсон тул 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дотор хүлээлгэн өгөх албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр гүйцэтгэгч компанид хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй гэсэн тайлбарыг тус сумын Засаг дарга өгсөн;
- Баянговь сумын иргэн Б.Амартүвшин сумын Засаг дарга Б.Бат-Амгалантай Хогийн нэгдсэн цэгт камер бэлтгэн нийлүүлэх гэрээг 6.0 сая төгрөгөөр байгуулж, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс хэтрэхгүй барааг хүлээн авагчид хүлээлгэн өгөхөөр заасан, 5.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байхад барааг хүлээлгэн өгөөгүй, ашиглаагүй;
- Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн камерын өргөтгөл, засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2025 оны 04 сарын 24-ны А/52 дугаар захирамжаар томилсон боловч тус ажлыг хүлээн авч, бүртгэлд тусгаагүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн хийгдсэн “Камержуулах /1,3,5,6,7,8,9, нийтийн эзэмшлийн зам талбайн шаардлагатай байршилд” ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан “Айти системс” ХХК гэрээний ажлын даалгаварт заасан 94 ширхэг камерыг анх хүлээн авахад ажиллаж байсан нь баримтаар нотлогдож байгаа ч аудитаар аймгийн нэгдсэн удирдлагын төвд биечлэн шалгахад 49 ширхэг камер ажиллаагүй байна.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн 33а/3664 дугаар албан бичигт сумдад хийгдсэн 2 ажлын сонгон шалгаруулах ажлын хэсэгт ороогүй, 2 ажлын хүлээн авах ажлын хэсэгт ороогүй, харин Баянхонгор сумд хийгдэж байгаа камержуулалтын бүх шатанд оролцож, хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Шийдвэрлэлт: Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт аймаг, сумдад хийгдэх камержуулалтын техникийн тодорхойлолтыг боловсруулах, хүлээн авах ажлын хэсэгт холбогдох мэргэжилтнээр хяналт хийлгүүлэн хүлээн авч байх болон дээрх ажлуудад холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын хамт хяналт хийж, арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3.1.3. Төрийн аудитын байгууллагаас 2024 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэрийг 91.8 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийт 5,747.1 сая төгрөгийн 75 зөрчил илрүүлснээс 201.3 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 5,200.8 сая төгрөгийн зөрчилд 49 албан шаардлага хүргүүлж, 345.0 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага өгсөн ба шийдвэрийн хэрэгжилт 91.8 хувьтай байна.

Баян-Овоо сумын ОНХС-д өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагуудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, шийдвэр гараагүй байгаа нь өмнөх аудитын шийдвэрийн биелэлтэд нөлөөлсөн байна.

Төрийн байгууллагын зарим албан хаагчид өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдан гарсан, ажлыг чанаргүй, дутуу хийсэн, гэрээний хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу байхад хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн хөрөнгө оруулалтын мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төсөл арга хэмжээний анхан шатны баримтын бүрдэл хангалтагүй, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн ажлын байршил өөрчлөгдсөн байхад гэрээ байгуулаагүй, санхүүжилт олгосон гүйлгээний баримтад өөр аж ахуйн нэгжийн нэрээр баримт материал ирүүлснийг хянаагүй, өмнөх оны аудитаар зөрчлийг давтан гаргасан тул БОНХОБТХ-ийн хөрөнгө оруулалтын мэргэжилтэнд;
- Ажлын байрны тодорхойлолтод заасан Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зарим ажлын техникийн тодорхойлолтыг зураг төсвөөс зөрүүтэй боловсруулсан, зураг төсөвт заасан ажлууд бүрэн хийгдээгүй байхад хяналт хэрэгжүүлэн хүлээн авсан тул аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дэд бүтэц барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэнд;
- Өмнөх оны аудитаар Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 оноос хэрэгжүүлсэн “Сумын төвийн гудамжны 0.4 кв-н ЦДАШ-н гэрэлтүүлгийн засвар, төрийн байгууллагын туузан гэрэлтүүлэг хийх” ажлыг “Их хотын гэрлэн дохио” ХХК 17.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 10.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2024 онд хийгдсэн 2023 оны ОНХС-ийн гүйцэтгэлийн аудитаар ажлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, акт үйлдээгүйд албан шаардлага хүргүүлсэн боловч ажлыг гүйцэтгүүлж хүлээн аваагүй тул Заг сумын ОНХС хариуцсан нягтлан бодогчид;
- Өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, аймгийн ГХБХБГ-аас сумын ОНХС-ийн хөрөнгөөр баригдаж байгаа орон нутгийн барилгын ажлыг зогсоох албан бичгийг хүргүүлсэн байхад гүйцэтгэгч аж ахуйн нэгжид 38.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй Баян-Овоо сумын санхүүгийн албаны дарга, ОНХС

хариуцсан нягтлан бодогч нарт, мөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр баригдаж байгаа сумын хуучин цэцэрлэгийг засварлаж ахмадын өргөө болгох ажлыг хийж дуусаагүй, одоо болтол барилгын ажлыг хүлээн аваагүй байхад тус барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр гаргасан бөгөөд тус баримтыг үндэслэн аймгийн ОНХС-аас 30.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон зөрчлийг сумын ЗДТГ-ын нягтлан бодогч гаргасан байна.

Шийдвэрлэлт: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1²⁴-т заасныг үндэслэн албан үүргээ биелүүлээгүй, Төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй 6 албан хаагчид хариуцлага тооцуулах албан шаардлагыг тэдгээрийг томилсон эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлэв.

Сумдын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 799.4 сая төгрөгийн 26 зөрчил илэрснээс 32.6 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, 690.6 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 76.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

3.2. Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3, 9.9 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.1. Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь сумдаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд журмын 9.3-т заасны дагуу тайлангуудад дүн шинжилгээ хийж, журмын 9.9-т заасан мэдээллийг бүрэн тусгаж, дүн шинжилгээнд тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж ажиллаагүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын журмын 9.3²⁵, 9.9²⁶-т заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Дээрх зөрчил өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар илэрч, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг үндэслэн аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн даргад албан шаардлага хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь сумдын 2024 оны ОНХС-ийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, ил тод байдал, төсвийн гүйцэтгэл, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн өмчлөл, ашиглалтын байдал зэрэгт хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Сумдын 2024 оны ЗДТГ-ын үйл ажиллагаанд аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний <https://bayankhongor.igovernment.mn/home/> цахим сангаар 17 төрлийн тайлан мэдээнд тулгуурлан хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн

²⁴ Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүрэгээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

²⁵ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

²⁶ “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана”

үнэлгээний нэг хэсэг болгон ОНХС-ийн үйл ажиллагаанд нийт 6 бүлэг, 35 үзүүлэлтээр үнэлгээ хийсэн. Тус хяналт шинжилгээ, үнэлгээнд Баянлиг, Баян-Өндөр, Галуут, Гурванбулаг, Жинст, Шинэжинст, Эрдэнэцогт гэсэн 7 сум ОНХС-ийн тайлангаа ирүүлээгүйгээс үнэлгээнд хамрагдаагүй ба бусад 13 сум үнэлгээнд хамрагдаж, дунджаар 82.9 хувьтай үнэлэгдсэн байна.

3.2.2. Аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөөр тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс 2,664.9 сая төгрөгийн 7 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Баянхонгор аймаг, сумдын дүнгээр 2024 онд сангийн хөрөнгөөр бий болсон нийт төсөл арга хэмжээний 92.3 хувь буюу 94,368.3 сая төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөд, 3.5 хувь буюу 3,625.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэж, 4.2 хувь буюу 4,262.5 сая төгрөгийг урсгал зардлаар тайлагнажээ.

Аудитын илрүүлэлт:

- Бөмбөгөр сумд 2018 оноос сумын болон аймгийн ОНХС-аас хэрэгжүүлсэн 1,430.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Спорт заал бүхий багийн хөгжлийн төвийн барилга" -ийн эзэмшигчийг тогтоож, орлогод бүртгээгүй;
- Баян-Овоо сумын ИТХ-аар баталсан "Музейн тохижилт хийх" ажлын хүрээнд "Ерөөл нэмэх" ХХК-аас нийлүүлэгдсэн нийт 81.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглаагүй, музейн хөрөнгийг орлогод аваагүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 197.7 сая төгрөгийн "Шуурхай удирдлагын төв-ийн ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын орон нутгийн барилгын их засварын ажлыг гүйцэтгэж байгаа "Буянт хөрс наран" ХХК нь Сангийн сайдын баталсан 278 дугаар журмын дагуу барилгын ажлын гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, барилгын ажилд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагууд хийгээгүй байхад санхүүжилтийг олгосон, 2023-2024 онд тус барилгын санхүүжилтэд нийт 636.9 сая төгрөгийг олгосон байхад нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Шинэжинст сумын ИТХ-аар баталсан "2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудын зураг төсөв хийлгэх" арга хэмжээний хүрээнд хийсэн 50.0 сая төгрөгийн зургийн үнийг санхүүгийн тайланд бүртгээгүй;
- Баянбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд бий болсон 20.0 сая төгрөгийн үнэ бүхий "Бод малын зөөврийн хашаа"-г орлогод авч бүртгээгүй;
- Баян-Овоо сумын орон нутгийн орлогоор 219.0 сая, аймгийн ОНХС-аас 30.0 сая төгрөгийг баталж хэрэгжүүлсэн Баян-Овоо сумын хуучин цэцэрлэгийг засварлаж ахмадын ордон байгуулах төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон байхад ажлыг хүлээж аваагүй, НББ-д тусгаагүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5²⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4²⁸, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2²⁹-т заасныг зөрчсөн эдгээр зөрчилд сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг орлогод авах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.3. Сангийн яамны ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системийн хөгжүүлэлт хангалтгүйгээс оруулсан мэдээллийг удаа дараа оруулдаг, аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн сумдад хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний мэдээллийг хэн оруулах нь тодорхой

²⁷ Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: хариуцлагатай байх

²⁸ Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна

²⁹ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

бусаас мэдээлэл оруулахгүй орхигддог, мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулахгүй өмнөх оны алдаа зөрчлүүд бүрэн арилахгүй байна.

Удирдлагын мэдээллийн систем нь иргэд, олон нийт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, явцын талаарх иж бүрэн мэдээллийг хүргэх зорилготой цахим мэдээллийн систем боловч тус системийг иргэд олон нийтэд таниулах ажил хангалтгүй, зарим сумдад санхүүгийн мэргэжилтэй боловсон хүчний дутагдалтай, боловсон хүчний тогтворгүй байдлаас шалтгаалан нэг нягтлан бодогчид ногдох ажлын ачаалал их, мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнуудын мэдлэг чадвар харилцан адилгүй, системийн хөгжүүлэлтийг тухай бүрд хийхгүй байгаагаас иргэд мэдээллийг цаг тухай бүрд, үнэн зөв авах боломжгүй, оруулсан мэдээлэлд үндэслэн буруу мэдээллийг авч бусдад түгээх, ойлголтын зөрүү үүсгэх зэрэг сөрөг үр дагавар үүсэхээр байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан 32,528.8 сая төгрөгийн 655 төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд оруулахаас 58.5 хувийг бүрэн, 33.9 хувийг дутуу оруулж, 7.6 хувийг удирдлагын мэдээллийн системд огт оруулаагүй, төсөл арга хэмжээний явцын болон эцсийн зургийг дутуу оруулснаас мэдээллийн зураг хангалтгүй, дутуу, өөр төсөл арга хэмжээний зургийг хавсаргах, иргэдийн саналын тоо байхгүй, төсөв, санхүүжилт, гэрээний дүн зөрүүтэй мэдээлэгдсэн байна.


Энэ нь Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2³⁰ дахь заалтыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд дараах сумд 2,810.8 сая төгрөгийн 50 төсөл арга хэмжээний мэдээллийг системд мэдээлээгүй орхигдуулсан, 15,348.0 сая төгрөгийн 222 төсөл арга хэмжээний мэдээллийг системд дутуу мэдээлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймаг 18, Баянхонгор сум 9, Жаргалант сум 3, Баацагаан сум 14, Бөмбөгөр, Баянбулаг, Баянцагаан, Галуут, Жинст, Заг сумд тус бүр 1 төсөл арга хэмжээг Удирдлагын мэдээллийн системд огт мэдээлээгүй;
- Баянхонгор аймаг 61, Баянхонгор сум 24, Баянговь 21, Жинст сум 11, Баянлиг сум 18, Эрдэнэцогт 14, Баян-Өндөр 15, Шинэжинст 9, Богд сум 7, Баацагаан сум 6, Хүрээмарал, Жаргалант, Бууцагаан сумд тус бүр 5, Өлзийт, Баян-Овоо сумд тус бүр 4, Заг, Гурванбулаг, Баянбулаг, Баянцагаан сумд тус бүр 3, Галуут сум 1 төсөл арга хэмжээг Удирдлагын мэдээллийн системд дутуу мэдээлсэн байна.

Аудитын явцад Баянхонгор аймгийн иргэдээс авсан санал асуулгын “ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системээс ямар мэдээлэл авдаг вэ?” гэсэн асуултад 32.9 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулсан ба 37.3 хувь нь төсөл арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой, 21.9 хувь нь сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой, 7.9 хувь нь худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг авдаг гэж хариулсан байна.



ОНХНС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохдоо Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл

³⁰ “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ”

ажиллагааны журам”-ын 10.3.2³¹ 10.3.3³² дахь заалтыг мөрдөж ажиллахгүй байгаатай холбоотойгоор УМС-д төсөл арга хэмжээний мэдээллийг дутуу оруулах, огт оруулдаггүй зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Шийдвэрлэлт: Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр сумдын ОНХС руу эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний мэдээллийг аймаг болон сумд Удирдлагын мэдээллийн системд оруулж мэдээлэхгүй байгаа, оруулсан мэдээллийг систем бүрэн гүйцэд татаж харуулахгүй байгаа зэрэг асуудлууд илэрч байгаа тул Сангийн яаманд Удирдлагын мэдээллийн системийн хөгжүүлэлтийг хийж, илэрч буй асуудал, хүндрэлүүдийг шийдэж ажиллахыг Сангийн яаманд толилуулахыг Дархан аймаг дахь Төрийн аудитын газарт уламжлав.

3.2.4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг Санхүү, төрийн сангийн хэлтэс бүрэн хэрэгжүүлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-тай холбоотойгоор сар бүр оруулах ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлэх, огт мэдээлэл оруулахгүй байх, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг байршуулалгүй орхигдуулсан зөрчлүүд бүрэн арилаагүй байна.

Аудитын илрүүлэлт

- Сар бүр мэдээлэх ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Баянхонгор аймаг 3 удаа, Шинэжинст сум 6 удаа, Баянбулаг сум 4 удаа, Баацагаан сум 3 удаа, Баян-Овоо, Галуут сумууд тус бүр 2 удаа, Эрдэнэцогт, Баянцагаан, Жаргалант, Баянговь сумд тус бүр 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим системтэй холбоотойгоор илэрч буй дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчим алдагдах, иргэд, олон нийт, хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, үнэ зөв, бодитой, иж бүрэн мэдээллийг олж авахгүй байх зэрэг үр дагаврыг тул Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Аудитаар нийт 6,978.5 сая төгрөгийн 75 зөрчил илрүүлж, 65.4 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 5,931.4 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 50 албан шаардлага өгч, 981.7 сая төгрөгийн 11 зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 4 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

---oOo---

³¹ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ”

³² “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй”

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд ОНХНС болон улсын төсвөөс Баянхонгор аймгийн ОНХС-д 21,577.0 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 20,790.0 сая төгрөг хуваарилж 787.0 сая төгрөг дутуу олгосон байна.
2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгийг зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, магадлалаар баталгаажаагүй, төсөвлөлтийн үндэслэл, шаардлагыг хангаагүй, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллага, шинжээчээр хянуулаагүй, иргэдийн саналд тулгуурлаагүйгээр төсөл арга хэмжээ баталдаг зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэт жижиг хэмжээний төсөл, арга хэмжээнд зарцуулснаар орон нутгийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх томоохон хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломж хумигдаж байна.
4. Аймаг, сумын ИТХ, СХДАГ, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсээс ОНХС-ийн хөрөнгийг зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгэж байгаад тавих хяналт хангалтгүй, хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын төлөөллүүд орж хяналтыг хэрэгжүүлээгүйгээс сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, ажлыг дутуу буюу чанаргүй гүйцэтгэх, хийхгүй орхигдуулах зэрэг зөрчлүүд бүрэн арилахгүй байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөлгүй, мэргэжлийн байгууллага, шинжээчээр хянуулж баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээг шат шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлан хэрэгжүүлж байгаа нь иргэд, тэр дундаа хүүхэд багачуудын аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
6. Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг нотариатаар баталгаажуулдаггүй, гэрээнд зайлшгүй тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгаагүйгээс цаг хугацаандаа хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хариуцлага тооцох, алдангийг төлүүлэхгүй байгаагаас ажил удаашрах тохиолдлууд нэмэгдэж, жил бүрийн аудитаар илрэх зөрчлийн тоо буурахгүй байна.
7. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилгын анхны санхүүжилтийг эрх бүхий байгууллагаас олгосон барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрлийг үндэслэн олгоогүй, гүйцэтгэлийн санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу бэлтгэсэн хавсралтын дагуу олгоогүй байхад аймгийн СТСХ, сумдын санхүүгийн албаны дарга нар хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
8. Аймаг, сумын Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд тусгасан “Худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай иргэдийг бэлтгэх” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, аймгийн Худалдан авах ажиллагааны газрын төлөөллийг хяналт шинжилгээ үнэлгээнд татан оролцуулж, ТБОНӨХБАҮХАТ-ийн хэрэгжилтийг хянуулж, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлээгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд өмнөх оноос нэмэгдсэн байна.
9. Сангийн яамны ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системийн хөгжүүлэлт хангалтгүй байгаатай холбоотойгоор мэдээллийг удаа дараа давтан оруулдаг, аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн сумдад хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг хэн оруулах нь тодорхойгүйгээс шалтгаалан мэдээлэл бүрэн оруулахгүй орхигдож байгаагаас оруулах мэдээллийг 33.9 хувийг дутуу мэдээлж, 7.6 хувийг удирдлагын мэдээллийн системд огт оруулаагүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

10. Аймаг, сумдын ЗДТГ-ууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогыг тодорхойлж, аймгийн хэмжээнд мөрдөх нэгдсэн арга зүйг боловсруулж ажиллаагүй байна.
11. Өвөлжилт хүндэрсэн онцгой нөхцөл байдлын үед аймгийн Засаг дарга болон аймгийн Онцгой байдлын комиссоос гаргасан шийдвэрт хэрэгжилтийн хугацааг тодорхой заагаагүйгээс шалтгаалан өвс, тэжээлийг шууд гэрээний аргаар худалдан авч, улмаар зарим суманд их хэмжээний чанаргүй өвс нийлүүлэгдэн хуримтлагдаж, цаашид ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.
12. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 2,664.9 сая төгрөгийн 7 хөрөнгийг нягтлан бүртгэлд тусгаагүй, сангийн хөрөнгөөр бий болсон 397.6 сая төгрөгийн 12 хөрөнгийг ашиглаагүй байна.
13. Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Шуурхай удирдлагын төв”-ийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.

САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах асуудлыг толилуулж байна. Үүнд

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН САНГИЙН ЯАМАНД УЛАМЖЛАХ САНАЛ:

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг мэдээлж байгаа Удирдлагын мэдээллийн системийн хөгжүүлэлтийг сайжруулах
2. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, сумын ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд тооцох хариуцлагын талаар заалт байхгүйгээс жил бүр аудитаар илрэх зөрчлийн тоо буурахгүй байгаа тул тус асуудлыг ЯАГ-аар дамжуулан Сангийн яаманд толилуулахаар хүргүүлэв.

АЙМГИЙН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсөвт өөрчлөлт оруулан батлахдаа техник эдийн засгийн үндэслэл хийгээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй, хууль, журамд нийцээгүй төсөл арга хэмжээг баталдаг байдлыг цаашид анхаарах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэт жижиг төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталсан нь орон нутгийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг өсгөх, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой томоохон хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг олгохгүй байгаад анхаарах.
3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөлийг байгуулж, хяналтыг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

СУМДЫН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсөвт өөрчлөлт оруулан батлахдаа техник эдийн засгийн үндэслэл хийгээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй, хууль, журамд нийцээгүй төсөл арга хэмжээг баталдаг байдлыг цаашид анхаарах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэт жижиг төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталсан нь орон нутгийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг өсгөх, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой томоохон хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг олгохгүй байгаад анхаарах.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ БАЯНХОНГОР
АЙМАГ ДАХЬ САЛБАРТ ТОЛИЛУУЛАХ НЬ:**

1. ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөлгүй, мэргэжлийн байгууллага болон шинжээчдээр хянуулж, баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээг шат шатны ИТХ-аар баталж хэрэгжүүлж байгаа нь иргэд, тэр дундаа хүүхэд багачуудын аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг толилуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Аймгийн Онцгой комисс болон Засаг даргын шийдвэрт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх хугацааг тодорхой зааж тусгах.
2. Худалдан авах ажиллагааны төсөвт зардлыг төлөвлөх, АЗ сертификаттай иргэдийг урамшуулж, идэвхийг нь нэмэгдүүлэх асуудлыг аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд тусган ажиллах.
3. Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Шуурхай удирдлагын төв”-ийг бүрэн ашиглалтад оруулах үйл ажиллагааг нь 2025 онд багтаан зохион байгуулах.

ХОЁР. АЙМГИЙН ЗДТГ-ЫН БОНХОБТХ-ИЙН ДАРГА Г.ЭНХБАЯР ТАНАА

1. Баянхонгор аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, зохион байгуулах.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГА, УЛСЫН БАЙЦААГЧ Н.МЭНДБАЯР ТАНАА

1. 2024 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хүүхдийн эргэн тойрны орчны бүсэд хэрэгжүүлсэн ажлуудад хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, цаашид уг төрлийн хяналтыг тогтмолжуулан хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАЯР ТАНАА

1. Аймаг, сумдад 2024 онд хэрэгжсэн, зөрчил илэрсэн таван төсөл, арга хэмжээнд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах, цаашид камержуулалтын ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулан, ашиглагч байгууллага хүлээн авахад оролцож хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.

ТАВ. АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА

1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилгын анхны санхүүжилтийг олгохдоо эрх бүхий байгууллагаас олгосон барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрлийг үндэслэх, цаашид Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний холбогдох заалтыг баримтлан санхүүжилтийг шат дараатайгаар олгох.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”

ЗУРГАА. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Н.БЯМБАДОРЖ ТАНАА

1. Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийж, арга зүйн дэмжлэг үзүүлэх, илэрсэн зөрчлүүдэд холбогдох арга хэмжээг авч ажиллах.

ДОЛОО. БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 дэх заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг бүрэн хамруулан хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх.

НАЙМ. СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөл, гүйцэтгэлийн чанар, техникийн тодорхойлолт, чанарын баталгаа, гүйцэтгэх хугацаа, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг төсвийн үнэ, зураг төсөв зохиогчийн хяналтын зардал зэргийг нарийвчлан тусгаж байх.
2. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээний нөхцөлийн дагуу алдангийг тооцож, хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх.